

**БУЛГАН АЙМГИЙН ЭДИЙН
ЗАСГИЙГ 2020 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ
ХӨТӨЛБӨР**

Булган 2005 он

БУЛГАН АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ 2020 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Монгол Улсын Их Хурлаас өргөн уудам нутаг дэвсгэрээ бүсчлэн хөгжүүлэх замаар хот хөдөөгийн ялгааг арилгах, жигд хөгжүүлэх бодлогыг тодорхойлж, бүсчлэн хөгжүүлэхтэй холбоотой хууль эрхзүйн орчин бүрдүүлэх дэс дараатай алхмуудыг хийн 2001 онд “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, 2003 онд “Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги”, “Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль”-ийг тус тус батлан гаргасан билээ.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын 2005 оны 202 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд “Булган аймгийн эдийн засгийг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулав.

Энэхүү хөтөлбөр нь 1997 онд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Чадавхи-21 сангийн ивээл дор боловсруулан аймгийн ИТХ-ын Ү хуралдаанаар батлуулсан “Булган аймгийн XXI зууны хөгжлийн хөтөлбөр”, 2000 онд Азийн Бүтээмжийн Холбоо, Монголын Үндэсний Бүтээмж Хөгжлийн Төв болон ХААИС-ийн дэмжлэг тусалцаатайгаар Токиогийн ХААИС-ийн Булганы Хөгжлийн Нэгдсэн Төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн боловсруулсан “Булган аймгийн Хөгжлийн Нэгдсэн Төлөвлөгөө”-тэй нягт уялдаатай юм. Эдгээр нь Булган аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн урт хугацааны бодлогын чанартай стратегийн гол баримт бичгүүд байх болно.

Хөтөлбөрийн зорилго: Аймгийн давуу талд тулгуурлан эдийн засгийн өсөлтийг тогтворжуулж чадавхийг нэмэгдүүлэх, хүн амын ажил эрхлэлт, боловсролын түвшинг нэмэгдүүлэх замаар хүний хөгжлийг дэмжиж, хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат: I үе шат 2006-2010, II үе шат 2011-2020

НЭГ. АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Манай аймагт улсын нийт нутаг дэвсгэрийн 3.1, хүн амын 2.4, малын 4.3 хувь ногдож байна.

Булган аймаг Монгол орны хойд хэсэгт байрлаж ОХУ, Хөвсгөл, Орхон, Сэлэнгэ, Төв, Өвөрхангай, Архангай аймгуудтай хиллэдэг, ойт хээр болон тал хээр хосолсон 48.7 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай, нийт нутаг дэвсгэрийн 40 орчим хувийг шилмүүст болон навчит ой эзэлдэг. Эх газрын эрс тэс уур амьсгалтай жилийн дундаж температур $+1.5C^0$, өвөлдөө дээд тал нь $-40C^0$ хүрч, зундаа $+33C^0$ хүрч дулаардаг, жилд дунджаар 344.2 мм хур тунадас унадаг.

56.7 мянган хүн амтай, 16 сум, 1 тосгон, 73 багтай, аймгийн төв Булган сум 11,9 мянган оршин суугчтай.

Жилдээ 21,0-27.0 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг нь улсын ДНБ-ний 1.5-2.0 хувийг эзэлдэг.

1.1 ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

Хөдөө аж ахуйн хөгжил

Тус аймаг 5 төрлийн 1.2 сая толгой малтай, 67.1 мянган га эргэлтийн талбайтай, жилд дунджаар 20.2 мянган га-д үр тариа тариалж нэг га талбайгаас 9,2 цн буюу 28.0 мянган тонн үр тариа, 760 га-д төмс, хүнсний ногоо тариалж 5,2 мянган тонн ургац хураан авч байна. Хураан авсан үр тарианы хэмжээ улсын хэмжээний хураан авсан нийт ургацын 20 орчим хувийг эзэлдэг, тариалангийн талбай, ургацын хэмжээгээр улсад дээгүүр ордог. Аймгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 70 орчим хувийг ХАА-н салбар үйлдвэрлэдэг бөгөөд үүний 38.5 хувийг газар тариалан, 61.5 хувийг мал аж ахуйн үйлдвэрлэл тус тус эзэлж байна.

Малын үүлдэр, удам угсааг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэн эрчимжүүлж, фермерийн аж ахуй эрхлэх явдал эхлэлийн төдий, зах зээлийн эрэлт нийлүүлэлтээс хамаарч сүргийн бүтцэд ч зарим сөрөг өөрчлөлт гарсан нь бэлчээр ашиглалтанд нөлөөлж байна. Цаашид мал аж ахуйн эрсдлийн менежментийн чадавхийг бий болгох замаар малчдын хөрөнгө орлогыг найдвартай хамгаалах, бүс нутгийн онцлог давуу талыг харгалзан мал аж ахуйг оновчтой түвшинд эрчимжүүлэх замаар салбарын бүтээмжийг дээшлүүлэх нь тулгамдсан асуудал болж байна.

Тариалж буй талбай, хураан авсан ургацын хэмжээгээр Булган аймаг улсад дээгүүр ордог хэдий ч сүүлийн 10 жилд дулааралтаас хамааран ууршилт их болж хөрсний чийгийн нөөц багасан бараг байнгын гантай байснаас газар тариалангийн үйлдвэрлэлийн хэмжээ жилээс жилд буурч аж ахуйн нэгжүүдэд амиа аргацаасан байдал давамгайлж, хөрөнгө санхүүгийн байдал доройтсоноос шалтгаалан техник шинэчлэх, сайн чанарын үрээр тариалах, бордох, услах, хог ургамалтай тэмцэх зэрэг санхүү, техник технологийн ажил орхигдож байгаа нь газар тариалангийн үйлдвэрлэлийн эцсийн үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

Аж үйлдвэр

Булган аймгийн аж үйлдвэрийн салбарын үйлдвэр жилд дунджаар 1.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

Орон нутагт алт олборлох үйл ажиллагаа эрхлэдэг аж ахуйн нэгж 9, нүүрс олборлодог аж ахуйн нэгж 2 ажиллаж байна. Үүнээс Бүрэгхангай суманд 8, Тэшиг суманд 1 алтны үйлдвэр, Гурванбулаг, Сайхан суманд тус бүр 1 нүүрсний уурхай үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн нутаг дэвсгэрт хийгдсэн хайгуул судалгаагаар алт, зэс, молибедин, чулуун нүүрс, зос, хаш, оюу, номин, шохойн чулуу, барилгын чулуу, хайрга зэрэг ашигт малтмал, эрдэс баялгийн 40 гаруй орд, 70 гаруй илрэл, 100 гаруй эрдэсжсэн цэг тогтоогоод байна.

Туул голын сав дахь алтны ордын нөөц 20 тн, Баянголын нөөц 13 тн, Тосонгийн нөөц 17 тн, Тэшиг сумын “Эрэн-Тавт”-ын алтны ордны геологийн нөөц 60 тн-оор тус тус тогтоогдсон.

2004 онд Булган аймагт “Айвен хоу майнз” “Адамс майнинг” “Алтан–Дорнод Монгол”, “Тедни майнинг” зэрэг 8 алтны уурхай 1226.7 кг алт олборлосон байна.

Сайхан сумын Эрээний ил уурхай 345.2 мян тн нүүрсний нөөцтэй жилд дунджаар 30000-45000 тн нүүрс олборлох хүчин чадалтай, 2004 оноос уурхайн үйл ажиллагаа тогтворжиж нүүрс олборлолтын хэмжээ нэмэгдэж байгаа бөгөөд аймгийн хэрэгцээг хангаад зогсохгүй Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц, Архангай, Хөвсгөл аймгийн хил залгаа захын сумдыг хангаж байна.

Мөн Гурванбулаг суманд орших Баяндуурахын нүүрсний уурхай жилдээ 2000-3000 мян тн нүүрс олборлож, аймгийн урд сумдын нүүрсний хэрэгцээг хангаж байна.

Манай аймагт боловсруулах үйлдвэр төдийлөн сайн хөгжөөгүй боловч жилдээ 15000 тн гурил, 10000 орчим тн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай Гурил, тэжээлийн үйлдвэр, спиртийн үйлдвэр, мөн талх нарийн боов, малын гаралтай түүхий эд боловсруулах болон оёдол, нэхмэл, сүлжмэлийн зэрэг жижиг цехүүд ажилладаг.

Булган аймагт мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, түүнийг боловсруулах үйлдвэрлэл явуулах нөхцөл бололцоотой боловч байгаль орчноо хамгаалах үүднээс үйлдвэрийн хаягдал усны цэвэрлэх байгууламжийн асуудлыг анхаарч, энэ чиглэлээр

тодорхой зорилт тавин хэрэгжүүлж чадвал аймаг орон нутгийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулах юм.

Аялал жуулчлалын хөгжил

Булган аймаг нь газар зүйн байршлын хувьд ОХУ-тай хиллэхээс гадна Монгол орны аялал жуулчлалын үндсэн нутаг болох аймгуудтай хил залгаа оршдог. Аймгийн нутаг дэвсгэр дээр 16 жуулчны бааз, 2 анчдын отог, 10 амралтын газар ажилладаг бөгөөд эдгээрээс 5 жуулчны бааз I зэрэглэлд, 3 жуулчны бааз II зэрэглэлд, 2 жуулчны бааз III зэрэглэлд тус тус ордог. Эдгээрээс Уран тогоо, Анаг тур ХХК-иас бусад жуулчны баазууд Улаанбаатар болон өөр аймаг хотын харьяалалтай байна. Жилд дунджаар 3000 орчим гадаадын жуулчин, 4000 гаруй дотоодын аялагчид ирж амардаг. Аймгийн хэмжээнд нийт 220 гаруй ортой, 70 орчим өрөөтэй, 24 зочид буудал байгаагаас нэг ч буудал улсын нэгдсэн зэрэглэлд хамрагдаагүй. Анаг тур ХХК-ийн амралтын газар 60 хүн, Зулзган түшиг зочид буудал 30 хүн хүлээн авах чадалтай. Бусад буудлууд нь ихэвчлэн 4-8 хүн хүлээн авах чадалтай байна.

Аялал жуулчлалын салбарыг зөв хөгжүүлснээр аймгийн эдийн засгийн хөгжлийг түргэтгэж, төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, шинээр ажлын байр бий болгох, байгалийн унаган төрх, экологийн тэнцвэрт байдлыг хангах боломж байна.

Дэд бүтцийн хөгжил

Аймгийн бүх сум, зарим багийн төвүүд төвлөрсөн эрчим хүчний хангамжид холбогдсон.

Дашинчилэн, Баяннуур зэрэг сумд мянганы замын траст хамрагдаж улсын нийслэлтэйгээ хатуу хучилттай хар замаар холбогдлоо. Бүсийн босоо тэнхлэгийн зам болох Эрдэнэт-Булган-Уньтын чиглэлийн замын ажил хийгдэж эхлээд байна.

Тус аймгийн 16 сум, төв суурин газарт телевиз, телефоны 25 станц ажиллаж, 16 сум суурин үндэсний телевиз болон Өвөрмонголын нэвтрүүлэг үзэж, аймгийн төвд Хийморь кабелийн телевиз, ЛХА телевиз үйл ажиллагаа явуулж байна. Мөн 2500 гаруй телефон цэг ажиллаж, хөдөлгөөнт холбооны Скайтель, Мобикомын үйлчлүүлэгчдийн тоо 2000 гаруй болж нэмэгдлээ. Булган-Мөрөн, Улаанбаатар-Дашинчилэн чиглэлийн дамжуулах сүлжээг шилэн кабелиар шинэчилж, Хутаг-Өндөр, Дашинчилэн сумд өндөр хурдны сүлжээнд хамрагдсанаар тус сумын иргэд хөдөлгөөнт холбооны системд холбогдоод байна.

Аймаг, сумын төвд тавигдсан электрон АТС-ын хэрэглэгчийн эрх авсны үндсэн дээр олон улсын ямар ч оронтой шууд ярих, интернетийн үйлчилгээ эрхлэх техникийн боломж бүрдэж, аймгийн төвд интернетийн үйлчилгээний цэг ажиллаж байна.

Санхүүгийн секторын хөгжил

2005 оны байдлаар Булган аймагт арилжааны 4 банк, даатгалын компаний 2 салбар, 2 төлөөлөгч ажиллаж иргэдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлж байна.

Арилжааны банкуудын зээлийн хүү сард дунджаар 2.5%-3.0% болж өмнөх онтой харьцуулахад 12-18 хувиар буурч, банкууд зээлийн бодлогоо жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх, жижиг бизнесийг дэмжихэд чиглүүлж ажилласан байна. Мөн жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор аймгийн төсвөөс 10.0 сая төгрөгийг арилжааны банкинд байршуулж, сарын 1%-ийн хүүтэй буюу банкны зээлийн хүүгээс бага хүүтэйгээр олгохоор ИТХ-ын ээлжит бус хуралдаанаар шийдвэрлэж сумдын иргэд, аж ахуйн нэгжид олголоо.

ХААН болон Шуудан банкны салбарууд оны эхнээс виза картаар, ХАС банкны салбар 4-р сарын 1-нээс мастер картаар үйлчилж үйлчилгээнийхээ хүрээг өргөжүүлэн сурталчилгааг эрчимжүүлж байна. Мөн Рашаант, Гурванбулаг сумд Онлайн сүлжээнд холбогдсоноор төлбөр тооцоо шуурхай хийгдэж байна.

ХАС банкны салбар нь хадгаламж зээлийн хоршоо үүсч бий болохыг дэмжих бодлого баримтлан ажиллаж ХЯБХ хэрэгжиж буй 8 суманд ХЗХ үүсгэн байгуулах анхан шатны сургалтуудыг бүрэн хийж мэдээлэл өгчээ. Тус салбар Хутаг-Өндөр суманд "Хан

намнан хөгжил” ХЗХ үүсэн байгуулагдахад туслалцаа үзүүлэн Франчайзын үйлчилгээ үзүүлж Булган, Орхон суманд ХЗХ үүсгэн байгуулахыг сонирхсон иргэдэд дараагийн шатны сургалтыг зохион байгууллаа. Зөвхөн тус банкны салбараас бичил зээлийн хүрээнд хөдөөний сумын багийн иргэн 940 хүнд 583.0 сая төгрөгний бичил зээл олгосон байна.

Хэдийгээр арилжааны банкуудын зээлийн хүү буурч, үйлчилгээний төрөл хэлбэр нэмэгдэж байгаа ч жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа өргөжүүлэх, тоног төхөөрөмж суурилуулахад урт хугацааны илүү бага хүүтэй хөрөнгө оруулалтын зээл нэн тэргүүн шаардлагатай байна.

Тус аймагт Монгол даатгал, Номин даатгал компаний салбар, Түшиг, Чин үйлс даатгалын компаний төлөөлөгч нар ажиллаж эхний хагас жилд даатгалын ач холбогдлыг сурталчлах, байгууллага иргэдэд учирч болох эрсдлийг бууруулах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулж нийт 2000 гаруй байгууллага, иргэдийг хамруулж 50.0 орчим сая төгрөгийн даатгалын хураамжийн орлого оруулж 4.5 сая төгрөгний нөхөн төлбөр олгосон байна. Үүний дийлэнхийг иргэд, байгууллагын тээврийн хэрэгслийн болон хөрөнгийн даатгал эзэлж байна.

Монгол даатгал Компаний салбар, Түшиг даатгалын төлөөлөгч нар газар тариалангийн даатгалыг хийж байгаа бөгөөд үрийн тариалангийн даатгалд 5 компанийг хамруулсан байна. Малжуулах төслийн хүрээнд төсөл хэрэгжиж буй суманд малын даатгалыг хийж тус даатгалаас 5.2 сая төгрөгний хураамжийн орлогыг бүрдүүлээд байна.

Даатгалын салбар компани, төлөөлөгчийн газраас иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад даатгалын ач холбогдол талаархи мэдээлэл, сурталчилгааг чанаржуулж, даатгалын төрөл зүйлийг нэмэгдүүлж ажиллах нь чухал юм.

1.2 НИЙГМИЙН ХӨГЖИЛ

Хүн амын өсөлт, хүний хөгжлийн талаар

Аймгийн хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь 1989 онд 2.1 улсын дундажтай ойролцоо, 2000 онд 1.6 буюу улсын дунджаас 0.2 пунктээр их байсан бол 2000 оноос эхлэн хүн амын тоо сүүлийн 5 жилд жил дараалан буурсаар 2004 оны байдлаар 56707 хүнтэй болж жилийн дундаж өсөлт сөрөг утгатай гарч хүн амын тоо хамгийн их буурсан 3 аймгийн нэг болжээ.

Аймгийн нийт хүн амын 30.0 хувийг 0-14 насны хүүхэд, 66.0 хувийг 15-65 насны хөдөлмөрийн насны хүн ам, 4.0 хувийг 65-аас дээш насныхан тус тус эзэлж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар шилжилт хөдөлгөөн хамгийн их байсан жил нь 2004 он буюу 3500 хүн шилжин явсан байна.

Аймгийн хүний хөгжлийн индекс /0.665/ улсын дундаж /0.690/-аас 3.6 хувиар бага, бүсийн дундаж /.646/-аас 2.9 хувиар их байна. Бүсийн бусад аймгуудтай харьцуулахад дундаж наслалт, боловсролын түвшний индекс харьцангуй өндөр байгаа нь ХХИ өндөр гарахад нөлөөлж байна.

Аймгийн хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх, шилжих хөдөлгөөнийг бууруулах шаардлагатай байна.

Хүн амын ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн талаар

2004 оны жилийн эцсийн байдлаар Булган аймаг 56.7 мянган хүн амтай байгаагаас хөдөлмөрийн насны хүн ам 34.2 мян /эмэгтэй 17.3 мянга/, ажиллах хүч 24.1 мянга /эмэгтэй 11.7 мянга/, эдийн засгийн үйл ажиллагааны салбарт 21.2 мянган хүн ажиллаж /эмэгтэй 10.1 мянга/ байна. Ажиллагчдын 64.1 хувь нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байна. 2004 оны жилийн эцсийн байдлаар ХХҮХ-т бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2.9 мянга, ажилгүйдлийн түвшин 12.2 хувь, ажиллах хүчний оролцооны түвшин 70.4 хувь байна. Нийт ажилгүйчүүдийн 48.8 хувь нь эрэгтэйчүүд, 51.2 хувь нь эмэгтэйчүүд, 52.3 хувийг 16-35 хүртэлх насны залуучууд, 84.6 хувийг мэргэжилгүй хүмүүс эзэлж байна. Ажил эрхлэлтийн түвшин 2004 онд 61.8 болж 2001 оныхоос 1.1 хувиар буурсан

нь шинээр ажлын байр бий болгох асуудалд анхаарах шаардлага гарч байна. Тус аймагт ажилгүйдлийн түвшин 12.2 хувь байгаа нь улсын дундажтай харьцуулахад 3.4 дахин, бүсийн дундажтай харьцуулахад 2.1 дахин өндөр байна.

Үүнтэй холбоотойгоор ядуурал ч бас харьцангуй их байна. Нийт хүн амын 38.7 хувь нь амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой амьдарч 100 хүн тутмын 39 нь хүнсний болон хүнсний бус зайлшгүй шаардлагатай хэрэглээний зүйлийг худалдан авах чадваргүй байна. Сүүлийн жилүүдэд жил дараалан ган, зудын бэрхшээл тохиолдож, мал сүрэг их хэмжээгээр хорогдсоны улмаас амьжиргааны эх үүсвэргүй болсон малчид аймаг, сумын төв, хот суурин газрыг бараадах болсон нь ядуучуудын тоог улам нэмэгдүүлэхэд хүргэж байна.

Зах зээлд ажиллах хүчний өрсөлдөх чадвар муу, мэргэжилгүй ажилгүйчүүдийн эзлэх хувь өндөр, ажилгүйдлийн үргэлжлэх хугацаа урт, бодит ажилгүйдэл төдийлэн буурахгүй байгаа зэрэг нь тулгамдсан асуудал болж байна. Мөн иргэдэд бизнес эрхлэж бие даан амьдрах мэдлэг, дадлага, туршлага дутмаг, бэлэнчлэх сэтгэлгээнээс түргэн салж чадахгүй байгаа зэргээс хамаарч ажилгүйдэл, ядуурал буурахгүй байна.

Мэргэжлийн сургалтын байгууллагын тогтолцоо шинэчлэгдээгүй, сургалтын хөтөлбөр, боловсролын уялдаа хангалтгүйгээс ажил олгогчийн захиалга, хэрэгцээнд тохирсон мэргэшилтэй, ур чадвартай ажиллах хүчин хомсдолтой байна. Аймагт ганц нэгээрээ буюу цөөн тооны хүмүүсээс бүрдсэн жижиг аж ахуйн нэгжүүд зонхилж, тэдгээрийн 60.4 хувийг жижиглэнгийн худалдаа эрхлэгчид эзэлж байна. Иймд эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын арга хэмжээ хэмжээтэй нягт уялдсан, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг шуурхай зохицуулахад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн идэвхитэй бодлого шаардлагатай байна.

Хүн амын боловсрол, соёлын талаар

Аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 25 сургуульд 12.4 мянган сурагч, МСҮТ-д 400 гаруй суралцагч сурч, 25 цэцэрлэгт 2200 хүүхэд хүмүүжин, дотуур байранд 1895 хүүхэд амьдарч байна. Суурь боловсролын хамран сургалт 91%, цэцэрлэгийн хамран сургалт 44.7%, иргэдийн бичиг үсэгт тайлагдалтын хувь 93.5% байна. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуульд 731 багш, сурган хүмүүжүүлэгч, 43 захирал эрхлэгч ажиллаж байна. Аймгийн нийт хүн амын 40 хувийг сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхдүүд эзэлдэг.

Боловсролын чанарт нөлөөлдөг хүчин зүйлст багшлах боловсон хүчний чадавхи, сургалтын орчин багтдаг. Гэтэл сургуулийн байр, суудлын тооны хүрэлцээ, тохижилт, хөдөөгийн сургуулийн дотуур байрны хүрэлцээ, сургууль, цэцэрлэгийн тохижилт, сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, лабораторийн хүрэлцээ хангамж тааруу байна. Мөн багш нарын арга зүйг шинэчлэх, тэднийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог эргэн харах шаардлагатай байна. Иймд дээрх шинэчлэлийг хэрэгжүүлэх боломж бүхий багшлах боловсон хүчнийг давтан сургах, сургалтын орчин бүрдүүлэх шаардлагатай. Үүнтэй уялдан 11 жилийн тогтолцоонд бүрэн шилжиж сургууль завсардалтыг арилгах, малчдын хүүхдийг СӨБ-д бүрэн хамруулах, багш нарын мэргэжлийг дээшлүүлэх аймгийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, АББ, зайны сургалтын хүрээг өргөтгөх, соёл, урлагийн ажлыг чанаржуулж хүрээг өргөтгөх, салбарын үйл ажиллагаанд мэдээлэл харилцаа холбооны технологийг нэвтрүүлэх зэрэг зорилтууд тавигдаж байна.

Хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар

Эрүүл мэндийн салбарт нэгдсэн эмнэлэг 1, сумын эмнэлэг 14, сум дундын эмнэлэг 3, ортой бага эмчийн салбар 3, багийн эмнэлэг 5, эмийн сан 18, өрхийн эмнэлэг 3 ажиллаж 2004 оны байдлаар магадлан итгэмжлэгдсэн 50 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн хэмжээнд эмнэлгийн 400 ортой. Эрүүл мэндийн салбарт 680 эмч, сувилагч, ажиллагсад ажиллаж 20 орчим нарийн мэргэжлээр хүн амд тусламж үзүүлж байна. Мөн хувийн хэвшилд уламжлалт эмнэлэг, эмэгтэйчүүд, мэдрэл, элэг цэс, хүүхдийн өвчнийг эмчлэх 43 ор бүхий 6 эмнэлэг ажиллаж байна. Тус аймгийн нэг их эмчид 645 хүн, 10000 хүн амд их эмч 17.2, эмнэлгийн дунд мэргэжилтэн 50.6

ногдож байна. Аймгийн хэмжээнд 1000 хүнд төрөлт 11,1, нас баралт 5,6, цэвэр өсөлт 5.5 байна.

2004 оныг өмнөх онтой харьцуулахад эх хүүхдийн эндэгдэл 26.9% буурч улс, аймгийн дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Хүн амын дунд халдварт өвчний гаралт нэмэгдэх хандлагатай байна. 2004 онд халдварт өвчний нийт 622 тохиолдол бүртгэгдсэн нь урьд онтой харьцуулахад 3.6 промилээр нэмэгдсэний дотор халдварт шар 26.5 хувь өндөр байна. Мөн аймгийн хэмжээнд сүүлийн 2 жилд БЗХӨ-ний тохиолдол 239-262, хүний боом 2-3 тохиолдол бүртгэгдлээ. Сүүлийн жилүүдэд байгаль цаг уурын өөрчлөлт болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр хүн амын дунд цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл, хавдар, осол гэмтлээс шалтгаалсан өвчлөл, нас баралт эхний 3 байрыг эзэлж байна.

Сумдын эмнэлгийн барилга байгууламжийг стандартын дагуу шинэчлэн, зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, эм хэрэгслээр хангах шаардлага бий болж байна. Сумын эмнэлгийн үйлчилгээнд 206 нэр төрлийн нэн шаардлагатай эм хэрэглэдэг бөгөөд эдгээрийн хангамж 50-60 хувьтай байна.

ЭЭС-ийн үйлчилгээг хөдөөгийн иргэдэд хүртээмжтэй хүргэх, чанарын баталгаатай боломжийн үнэтэй эмээр хангах явдал хангалтгүй байсаар байна.

1.3 БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ

Газрын нөөцийн ашиглалт, хамгаалал

Булган аймаг нийт 4873.3 мянган га нутаг дэвсгэртэй. Нийт нутгийн 39.09%-ийг холимог ой, 56.75%-ийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 0.57%-ийг хот тосгон бусад суурины эдэлбэр газар, 0.16%-ийг зам шугам сүлжээний эдэлбэр газар, 0.46%-ийг усан сангийн эдэлбэр газар, 2.98%-ийг улсын тусгай хэрэгцээний газар тус тус эзэлж байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд 2747.4 мянган га ашиглагдаж байгаагаас 112.0 мянган га талбай хадлан, 2522.3 мянган га газар бэлчээр, 113.1 мянган га тариалангийн талбай байдгаас тухайн жилийн цаг уурын байдалтай уялдан жилд дунджаар 60.0 мянга орчим га хадлангийн талбайг ашиглаж байна.

Сүүлийн жилүүдэд ган, зуд болж зэргэлдээ аймаг, сумдаас мал ихээр орж ирж байгаа зэргээс шалтгаалан бэлчээрийн талхагдал ихсэж байгаатай холбогдуулан 2001-2004 онд 29.8 мянган га бэлчээрийн даацыг тохируулж, 9.4 мянган га бэлчээрийг малын хөлөөс чөлөөлж, 390.6 мянган га бэлчээрийг сэлгэн ашигласны гадна 895.9 га газрыг 5789 өрхөд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэн нь аймгийн нийт өрхийн 37% болж байна.

Газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулж, газрын төлөв байдал, чанарыг бууруулахгүй байлгах зорилгоор 781 га газрыг дуудлага худалдаагаар 35 иргэн, 7 аж ахуйн нэгжид олгон гэрээ байгуулан ажиллаж байна. Хөрсний үржил шим муудаж, элэгдэл эвдрэлд орсон 6328 га тариалангийн талбайд нөхөн сэргээх ажил хийгдэж байна.

Цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх

Манай аймагт хүний хүчин зүйлээс үүдэлтэй бэлчээрийн даацыг хэтрүүлэн ашиглах, ойг огтлох, ойн түймэр, олон салаа зам гаргах, уул уурхайн зориулалтаар газрыг сэглэж сэндийлэх, тариалангийн хөрсийг элэгдэл эвдрэлд оруулах зэргээс шалтгаалж цөлжилт явагдаж байна. Булган аймгийн урд бүсийн газар нутаг хөрсний доройтол, элсний нүүлтэд өртөж байгаагаас Гурванбулаг, Дашинчилэн, Баяннуур сумдын төв элсэнд дарагдан цөлжиж байна. Сүүлийн 10 жилд өмнөх жилүүдээс шороон шуургатай өдрийн тоо 3-4 дахин нэмэгджээ.

Гурванбулаг, Дашинчилэн, Баяннуур, Рашаант сумдад цөлжилттэй тэмцэх олон улсын болон орон нутгийн төслийг нэн даруй хэрэгжүүлж, Могод, Хишиг-өндөр, Бүрэгхангай, Сайхан, Орхон, Баян-Агт, Булган зэрэг сумдад цөлжилттэй тэмцэх шаардлагатай болж байна.

Улсын тусгай хамгаалалттай газар нутаг

Манай аймгийн тусгай хамгаалалттай газар нутаг нийт нутгийн 2,4 хувь буюу 144981 га талбайг эзэлдэг.

Өндөр уул, ойт хээрийн бүсэд орших тусгай хамгаалалтай газар нутгуудад манай орны багахан ойн нөөц байдаг ч байгаль хамгаалал болон байгалийн нөөц ашиглалтын талаархи зөрчлийн 40 орчим хувь нь тохиолддог, хавар, намрын төдийгүй зуны хуурайшилттай үед түймэр их гардгаас тусгай хамгаалалттай газар нутгуудад ойн түймрээс хамгаалах менежментийг хэрэгжүүлэх нь чухал юм.

Булган аймаг байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалан үлдэж чадсан хэдий ч зарим нутагт малын бөөгнөрөл ихсэх, тариалангийн талбай их хэмжээгээр эвдрэн, хөрсний экологийн эмзэг орчин бий болсон энэ нөхцөлд нутаг дэвсгэрийн 10-15 хүртэл хувийг улсын тусгай хамгаалалтад авах шаардлагатай болж байна.

Ойн нөөцийн ашиглалт, хамгаалал

Булган аймгийн нийт нутаг дэвсгэрийн 39.1 хувийг буюу 1905.3 мянган га талбайг ойн сан бүхий газар эзэлдэг. Модны төрлөөр авч үзвэл нарс мод 3.47%, шинэс 73.19%, хуш 3.58%, хус 18.2%, гацуур 0.06%, улиас 0.15%, улиангар 0.06%, хайлаас 0.16%, бургас 1.15%-ийг тус тус эзэлж байна. Тус аймгийн ашиглалтын ойн гол нөөц газар Тэшиг, Хутаг-Өндөр сумдад байдаг боловч ойн нөөц багатай Сэлэнгэ болон ойн нөөцгүй Бугат, Орхон, Хангал сумдаас жилийн модны хэрэгцээг бэлтгэж байна. Тус аймгийн байгаль орчны тулгамдаж буй асуудлын нэг бол ойн сангийн хомсдол юм. Манай аймгийн хэмжээнд ойгоор бүрхэгдсэн талбай 2004 онд 39.1 хувь болсон нь модыг эмх замбараагүй бэлтгэж байгаа болон түүнд тавих хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилт сул, ойн түймэрт автагдах, залуу модод малын хөлд өртөх, хөнөөлт шавьжинд идэгдэж байгаа зэрэг хүчин зүйлсээс болж байна. Сүүлийн үед ойн түймэр ихээр гарч байгаа нь ой сийрэгжих үүний нөлөөгөөр хур тунадас багасах, жижиг гол горхи ширгэх, ингэснээр ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт гарахад нөлөөлж байна. Манай аймгаас улсын нийт хэрэглээний модны 59.2 хувь, түлээний модны 12.3 хувийг бэлтгэж байна. Цаашид ойн санг ашиглалт талаас биш, ойг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр бодлого барьж ойн менежментийг сайжруулах хэрэгтэй байна.

Усны нөөцийн ашиглалт хамгаалал

Булган аймгийн нийт нутаг дэвсгэрийн 0.4 хувь буюу 22239.3 га талбайг усан сан бүхий газар эзэлдэг. Аймгийн хэмжээнд нийт 671 уст цэг байдгаас 238 нь л ашиглагдаж байгаа бөгөөд 433 нь эвдэж тоногдсон, усгүй болсон, усны түвшин буурсан, лайд дарагдсан, эзэнгүйдсэн байна. Төв, суурингийн усны хангамж хангалтгүй бөгөөд эрүүл ахуйн шаардлагыг тэр болгон хангахгүй, Дашинчилэн, Баяннуур, Гурванбулаг сумын төвүүдэд ундны усан хангамж дутагдалтай байна. 2003 оны аймгийн гадаргын усны тооллогоор нийт 498 гол горхины 63, 714 булаг, шандны 245, 261 нуур, цөөрмийн 27 нь ширгэсэн байгаа бөгөөд цаашид энэ байдал ихсэх хандлагатай байна.

Иймд гол, мөрөн, нуур, цөөрмийг тэжээж тэтгэж байдаг, хүн ам болон малын ундны эх үүсвэр болсон жижиг гол горхи, булаг шандны эхийг хамгаалах шаардлагатай байна.

Агаар мандлын ашиглалт, хамгаалал

Аймгийн уур амьсгалын горим 1968 оноос судлагдсан боловч агаарын төлөв байдал, түүний бохирдолтын хэмжээ аймгийн хэмжээнд бүрэн судлагдаагүй байна. Төв суурин газрын дулааны системийн хоцрогдлоос шалтгаалан агаарт үүсч буй утаа, хог хаягдал агаарын бохирдолд нөлөөлж байна. Мөн автомашины тоо эрс нэмэгдэх болсноос гэр хорооллын айл өрхүүд хот, сууринг ихээхэн бохирдуулж байна.

Төв, суурин газруудад аж ахуйн нэгж, байгууллагууд зардал хэмнэх зорилгоор халаалтаа нэгдсэн системээс салгаж, тус тусдаа уурын зуух барих, энгийн галлагаанд шилжих болсон нь бохирдуулагч эх үүсвэрийн тоог нэмэгдүүлжээ. Хот, суурин газруудад хөрсний элэгдэл эвдрэл их, цэцэрлэгжүүлэх ажил хангалтгүй байна.

Биологийн төрөл зүйлийн ашиглалт, хамгаалал

Булган аймаг нь ан амьтан, ургамлын олон зүйл баялаг нөөцтэй аймгийн тоонд ордог. Хандгай, баавгай, буга, бор гөрөөс, гахай, хүдэр, шилүүс, үнэг, хярс, чоно, тарвага ан амьтан, олон зүйлийн шувуу, тул, зэвэг, алгана цурхай зэрэг загастай. Мөн эмчилгээний чанартай нөөц тархац багатай ховордсон ургамал болох заан хүж, жудаг өвс, лидер өвс, яргай зэрэг болон чихэр өвс, ганга, бамбай, мэхээр, царгас, нохойн хошуу, бөөрөлзгөнө, юмдүүжин гэх мэт эмийн ургамал болон чацаргана, нэрс, аньс, мойл, улаалзгана, үхрийн нүд зэрэг жимс, жимсгэнэ ургадаг.

Сүүлийн жилүүдэд хулгайн ан ихсэж байгаа нь ан амьтны байршил өөрчлөгдөн, сүргийн бүтэц алдагдан, тоо толгой нь багасахад нөлөөлж байна.

Аймгийн биологийн төрөл зүйлийн бүх нөөц, баялгийг бүрэн хэмжээгээр судалж, хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх талаар мэргэжлийн байгууллагын судалгаа, шинжилгээ, дүгнэлт нэн чухал шаардлагатай байна. Орон нутгийн иргэдийн биологийн төрөл зүйлийн талаархи мэдлэгийг ч мөн сайжруулах шаардлагатай байна.

Байгалийн гамшгийн аюулыг бууруулах

Хөгжлийн аливаа төлөвлөлтөнд байгалийн гамшиг болон бусад нөлөөллийн хүчин зүйлүүдийг харгалзах нь түүний цаашдын хөгжлийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх боломж бий болгодог. Эдийн засаг, нийгмийн салбаруудын хөгжлийг сааруулах, хэсэг хугацаагаар зогсоож ухрааж ч мэдэх байгалийн гамшгууд дэлхийн болон бүс нутгийн байгаль цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэйгээр тус аймгийн нутаг дэвсгэрт тохиолдож байгаа бөгөөд тохиолдох магадлал, түүний учруулах хор хөнөөл, уршиг хөгжлийн шаттай уялдан улам ихсэх шинжтэй байна. Сүүлийн 5 жилд тус аймгийн нутаг дэвсгэрт гамшгийн улмаас 600000 гаруй мал хорогдож, 2500 га талбайн ургац алдаж, 101 удаагийн ой хээрийн түймэр гарч, олон удаагийн гамшигт зам гүүр, цахилгааны болон холбооны шон, байшингийн дээвэр, айлын гэр унаж, их хэмжээний хохирол учруулсан байна. Аймгийн эдийн засгийн голлох салбар хөдөө аж ахуй нь байгаль цаг уураас шууд хамааралтай эрсдэл өндөр салбар бөгөөд ган, зуд болон түүний дам гамшгийн аюулыг бууруулахад өнөөгийн байдлыг зөв үнэлэх, эрсдэл эмзэг байдлыг тодорхойлон түүнийг багасгах арга хэмжээг үе шаттайгаар авах шаардлагатай байна.

Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослоос хамгаалах тогтолцоо бүрэн утгаараа бүрэлдэн тогтоогүй, гамшиг ослын аюулаас хамгаалах мэргэжил, дадлагын түвшин дутмаг, ард иргэдийн ойлголт сул, холбоо зарлан мэдээллийн нэгдсэн сүлжээ байхгүй зэрэг нь тулгамдсан асуудал болж байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийн салбар бүрийн хөгжлийн одоогийн байдлыг нэгтгэвэл Булган аймаг нь хөгжлийн дараахь давуу болон сул талтай байна.

Давуу тал:

- Байгаль цаг уурын харьцангуй тааламжтай нөхцөлтэй, ой мод, ан амьтан, ургамлын төрөл элбэг, аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой
- Дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн, төмөр зам, агаарын болон авто замын улсын сүлжээнд ойр, бүх сум, зарим баг төвийн эрчим хүчний системд холбогдсон
- Газар тариалан хөгжүүлэх байгаль цаг уурын нөхцөл зохицсон, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн мах, сүү цагаан идээ, гурил, тэжээл, төмс хүнсний ногоогоор өөрийгөө хангах боломжтой
- Ашигт малтмалын болон эрдэс баялгийн багагүй нөөцтэй

Сөрөг нөлөөлөх тал:

- Аймгийн эдийн засгийн голлох салбар мал аж ахуй, газар тариалан нь байгаль цаг уураас шууд хамааралтай, эрсдэл ихтэй, нэгжээс авах ашиг шим бага
- Аж үйлдвэрийн салбар тухайлбал хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэл хөгжөөгүй
- Хүн амын жилийн дундаж өсөлт буурч, шилжилт хөдөлгөөн нэмэгдсэнээс хүн амын тоо харьцангуй цөөрч буй, цөөрөх хандлагатай

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, давуу болон сул талыг харгалзан 2020 он хүртэл хэрэгжүүлэх ажил, хүрэх үр дүн, тэргүүлэх зорилтыг салбар тус бүрээр тодорхойлж байна.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТЛЭГ АРГА ХЭРЭГСЭЛ

Аймгийн эдийн засгийг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, гадаад хамтын ажиллагаа болон бүсийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, бүх нийтийн оролцоог хөхиүлэн дэмжих зэргээр хөгжилд түлхэц өгөх нийтлэг арга хэрэгслүүдийг оновчтой зөв сонгон ашиглах нь чухал юм.

3.1 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын үндсэн чиглэл

✦ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар орон нутгийн удирдлага, хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд, иргэдийн оролцоог хөхиүлэн дэмжих оновчтой арга хэрэгсэл, механизмыг тогтоох

✦ Жил жилийн улсын болон орон нутгийн төсөв, дунд хугацаны төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засаг, нийгмийн салбар бүрээр боловсруулан хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүдэд энэхүү хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагааг аль болохоор уялдуулах

✦ Хөтөлбөрт дэвшүүлсэн зарим тэргүүлэх зорилтуудыг урт, богино хугацааны тусгай төсөл болгон боловсруулж хэрэгжүүлэх

✦ Хөтөлбөрт дэвшүүлсэн тэргүүлэх зорилтууд, тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг аймаг, сумдын Засаг дарга нар мөрийн хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэх

✦ Цөлжилттэй тэмцэх зардлыг улс, орон нутгийн жил бүрийн төсөв болон бусад эх үүсвэрт тусгах

✦ Үйлдвэр, уурхайд усыг эргүүлэн ашиглах, цэвэршүүлсний дараа урсгал усанд нийлүүлдэг болгоход тавих төр, олон нийтийн хяналтыг хүчтэй болгох

3.2 Эдийн засгийн өсөлтийг хангах үндсэн арга хэрэгсэл

✦ Орон нутгийн өмч, санхүү, зээлийн эрх мэдлийг өргөтгөх

✦ Орон нутгийн төсвийг эдийн засгийн бодлоготой нягт уялдуулж, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүний хэмжээгээр санхүүжилт олгодог журамд бүрэн шилжих

✦ Ажлын байр шинээр бий болгосон, техник технологийн шинэчлэл хийсэн аж ахуйн нэгжид эдийн засгийн дэмжлэг үзүүлэх

✦ Үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зориулсан урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгохыг дэмжих

✦ ОХУ-ын Буриад улсын Закамень районтой хамтын ажиллагааг эрчимжүүлэх

✦ Малгүй, цөөн малтай өрхийг олон улсын байгууллагын төслөөр малжуулах арга хэмжээ авах

✦ Аймгийн төв, суурингийн дэргэд өндөр ашиг шимтэй цэвэр, эрлийз мал үржүүлэх эрчимжсэн аж ахуй байгуулахад гадаадын хөрөнгө оруулалтыг түлхүү ашиглах, нутгийн шилмэл омгийн мал үржүүлэн борлуулж байгаа аж ахуйн нэгж, малчдыг зээлийн бодлогоор дэмжих

✦ Газар тариалангийн үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлэх чиглэлээр гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх

✦ Мал, тариалангийн үйлдвэрлэлийг даатгалын ба эрсдэлийн тогтолцоонд бүрэн хамруулах

✦ Аялал жуулчлал эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн татварыг тухайн орон нутагт нь авах, хяналт тавих санхүүгийн механизмд шилжих

✦ Хүн амыг эдийн засаг, экологийн хосолмол боловсрол, хүмүүжилтэй болгох арга хэмжээ авах

✦ Ядуу өрх айл, иргэдэд зориулсан бичил санхүүгийн үйлчилгээг бий болгох, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, тусламжийг зохицуулах, оновчтой зарцуулах, түүнд тавих хяналтыг сайжруулах

3.3 Олон нийтийн оролцоо

- ✦ Нутгийн өөрөө удирдах байгууллагын зохицуулалтын эрх мэдлийг өргөтгөж, орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
- ✦ Эдийн засаг, нийгэм, байгаль орчны хөндлөнгийн хяналтыг олон нийтийн хяналтад шилжүүлэх
 - ✦ Өрхийн аж ахуй эрхлэхэд туслах сайн дурын байгууллага бий болгох
 - ✦ Малын хулгайтай тэмцэхэд иргэдийн оролцоог идэвхжүүлэх арга хэмжээ авах
 - ✦ Соёл урлагийг хөгжүүлэхтэй холбоотой иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжих
 - ✦ цөлжилттэй тэмцэх үйлсэд иргэд, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагыг татан оролцуулж, хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулж, үр өгөөжийг дээшлүүлэх
 - ✦ Хамтын эзэмшлийн ой байгуулах, ойжуулах, ойн хортон шавьж устгах арга хэмжээнд олон нийтийг татан оролцуулах
 - ✦ Усны эх үүсэврийг хамгаалах уламжлалт арга, зан үйлийг сэргээн хөгжүүлэх
 - ✦ Нутгийн уугуул иргэдэд биологийн төрөл зүйлийг хамтран хамгаалах, ашиглах, үржүүлэх асуудлыг хариуцуулах

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилт, гарч буй үр дүнд үнэлгээ өгч, хөтөлбөр хэрэгжих таатай нөхцөл бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр хийж байхын зэрэгцээ үе шат бүрийн эцэст буюу 2010, 2020 онуудад дүгнэнэ.

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтод хүрэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, гадаад дотоодын хөрөнгө оруулалт, Олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагын тусламж, дэмжлэг, зээл, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өөрийн хөрөнгө, хандивын хөрөнгөөс бүрдэнэ.

Аймгийн ИТХ-ын 4 дэх удаагийн сонгуулийн
2005 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн
Ү хуралдааны 05/07 тоот тогтоолын хавсралт

Булган
ХОТ

№	Тэргүүлэх зорилт	Бүлэг, дэд бүлэг, хэрэгжүүлэх арга хэмжээ	Гарах үр дүн	Хугацаа
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ				
2.1 Эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлж, салбарын зохистой бүтэц бий болгох бодлого				
	Бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж, аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг 10.0 хувьд хүргэнэ	Аймгийн давуу тал, нөөцөд тулгуурласан эдийн засгийн шинэ салбар, шинэ үйлдвэрлэлийг бий болгох бодлогыг хэрэгжүүлэх	Аймгийн ДНБ-д аж үйлдвэр, үйлчилгээний салбарын эзлэх хувийн жин нэмэгдэж, бизнес эрхлэх таатай орчин бүрдэнэ	2006-2010
		"Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнийг сум бүрт өрнүүлж, чанар сайтай, өрсөлдөх чадвар бүхий "брэнд" бүтээгдэхүүн шинээр бий болгож, дотоод гадаадын зах зээлд гаргах		
		Арьс шир, ноос ноолуур, сүү сүүн бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн, гурил гурилан бүтээгдэхүүн, ургамал, амьтны гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрүүдийг эхний ээлжинд байгуулахыг дэмжих		
		Бөөний худалдааны сүлжээ хөтөлбөрийг хэрэгжүүлнэ		
		ОХУ-тай хил залгаа Тэшиг сумын Бага Илэнх-Айнекийн боомтыг байнгын ажиллагаатай болгох		
		Уул уурхайн орчин үеийн техник, технологи бүхий үйлдвэрүүдийг байгаль орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн байгуулах		
	Аймгийн ДНБ-д аж үйлдвэр, үйлчилгээний салбарын бүтээгдэхүүний хэмжээг тогтвортой нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг 10-15 хувьд байлгана.	Экспортын баримжаатай, хувийн хэвшилд тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг түлхүү хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах	Өөрийгөө тэтгэх боломж бүхий эдийн засгийн зохистой бүтэц бий болно	2011-2020
		Боловсруулах аж үйлдвэр, уул уурхайн үйлдвэрлэл давамгайлсан, эрчимжсэн хөдөө аж ахуй бүхий аялал жуулчлал, үйлчилгээний салбар хөгжсөн аймгийн эдийн засгийн зохистой бүтцийг бий болгох бодлого хэрэгжүүлэх		
		Сумдыг бүсчлэн хөгжүүлж, бичил бүсүүдийг эдийн засгийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх		

		Хөдөө аж ахуйн экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх		
		Нутгийн өөрөө удирдах байгууллагын эдийн засгийн зохицуулалтын эрх мэдлийг өргөтгөхөд анхаарч, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх		
2.2 Мал аж ахуйн хөгжил				
		Бэлчээрийн даац, усан хангамжийг харгалзан мал сүргийг зохистой тоо, бүтэцтэйгээр өсгөн үржүүлэх бодлого баримтлах, ялангуяа таваарлаг тэмээ, үхэр өсгөхөд анхаарах		
		Шилмэл малын удмын сан бүрдүүлэх		
		Өндөр ашиг шимтэй махны чиглэлийн Сэлэнгэ үхэр, мах-сүүний Алатау, сүүний Хар тарлан, баяд, Дархад, Хотонт хонь, Эрчмийн хар, Баяндэлгэрийн улаан зэрэг үүлдэр омгийн малаар нутгийнхаа мал сүргийг сайжруулахад ашиглах		
		Сумдын түвшинд хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироог зохистой түвшинд болгох ажлыг шийдвэрлэх		
		Мал сүргийн удмын санг сайжруулах, нэгжээс авах ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор хонь, үхэрт зохиомол хээлтүүлэг хийх		
		Эхний ээлжинд Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Бугат, Хангал, Булган сумдад мах сүүний чиглэлээр эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх		
	Бэлчээрийн мал аж ахуйг зах зээлийн эрэлт, хэрэгцээ, бүс нутгийн онцлогт тохируулан үр ашигтай эрхлэн хөтлөх арга хэлбэрт шилжүүлэх	Орхон, Бүрэгхангай, Баян-Агт сумдад нарийн ноост хонь Хангай үүлдрийн хонийг өсгөн үржүүлэх ажлыг дэмжих	Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хэмжээг 2005 онтой харьцуулахад жилд дунджаар 10 хувиар өсгөнө. Нийт сүргийн дотор өндөр ашиг шимтэй болон нутгийн шилмэл омгийн малын эзлэх хувийн жинг 20 хувьд хүргэж, малын өвчнөөр хорогдох тоо хэмжээг 2004 онтой харьцуулахад 50 хувиар бууруулна	2006-2010
		Малын сүүгээр олон төрлийн бүтээгдэхүүн хийдэг уламжлалт аргыг дэлгэрүүлж, энэ чиглэлийн боловсруулах савлах жижиг үйлдвэрийг олшруулан экологийн цэвэр бүтээгдэхүүн гарган зах зээлд нийлүүлэх		
		Малын усан хангамжийг нэмэгдүүлэх		
		Аймгийн төв болон Орхон аймгийн ойролцоо мах, сүүний эрчимжсэн мал аж ахуйг өргөжүүлэх		
	Бэлчээрийн мал аж ахуйг материаллаг бааз талаас нь хагас суурин хэлбэрт шилжүүлэх,	Үржлийн сайн чанарын өсвөр бух, гунж бойжуулан сүү, махны чиглэлийн үхэр үржүүлэх мал аж ахуйн нэгжүүдийг өргөтгөх	Аймгийн мал сүргийн дотор өндөр ашиг шимтэй болон нутгийн шилмэл омгийн малын эзлэх хувийн жинг 30 хувьд хүргэж, МАА-н	2011-2020

	технологи талаас нь эрчимжиж байгаа аж ахуй болгож экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж, мал сүргийг эрүүлжүүлнэ	Сэлэнгэ үүлдрийн үхрийг аймгийн хэмжээнд үхэр сүргийн үндсэн сайжруулагчаар ашиглаж, Хутаг-Өндөр, Сэлэнгэ сумдад үржлийн аж ахуйг байгуулах	бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг жилд дунджаар 12 хувиар өсгөж, малын халдварт, паразитат өвчнөөс урьдчилан сэргийлнэ	
		Өндөр ашиг шимт малын хээлтүүлэгч, түүний үр хөврөлийг үржилд өргөн ашиглах		
		Нарийн ноост Хангай үүлдрийн хонины фермийг Бүрэгхангай, Баян-Агт сумдад байгуулах		
2.3 Газар тариалангийн хөгжил				
	Салбарын хүрээнд шинжлэх ухааны ололтыг өргөн ашиглаж газар тариалан, мал аж ахуйг хослон эрчимжүүлэн хөгжүүлэх, дотоодын хэрэгцээг бүрэн хангаж улсын хэрэгцээнд тодорхой хувь нэмэр оруулах	Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөтлөн явуулах систем боловсруулж мөрдүүлх	Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулж, усалгаатай тариалангийн хэмжээг 2005 оныхоос 3 дахин нэмэгдүүлж, дэвшилтэт технологи нэвтрүүлснээр хүн амын гурил, төмсний хэрэгцээг 100.0 хувь, хүнсний ногооны хэрэгцээг 70.0 хувь хангана	2006-2010
		Хөрс боловсруулах дэвшилтэт технологи, цомхотгосон болон тэг элдэншүүлгийг нэвтрүүлж эрдэс шим бордооны хэрэглээг өргөжүүлж, ойн зурвас байгуулах замаар хөрсний элэгдэл, эвдрэл, үржил шимийг сайжруулах		
		Сэлэнгэ, Орхон, Эг зэрэг голын сав дагуух нутагт усалгаатай тариалан эрхлэх, хайгуул судалгаа, зураг төсөл хийх, систем байгуулах ажлыг иргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгөөр болон улсын захиалга, хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэх		
		Газар тариалангийн эрчимжсэн үлгэр жишээ загвар аж ахуйн нэгжийг 2-3 суманд байгуулж, шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх түшиц газар болгох		
		Үйлдвэрлэлийн зохион байгуулалт, эдийн засгийн чадавхи, техникийн хүчин чадал сайтай аж ахуйн нэгж, фермер, үрийн аж ахуй байгуулах замаар ганд тэсвэртэй сайн чанарын нутагшсан үрээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах		
		Хамгаалагдсан хөрсний таримлын хэмжээг нэмэгдүүлэх, жимс, жимсгэний тарьц суулгац үржүүлэх, зорь агуулахын аж ахуйг хөгжүүлэх		

		Газар тариалангийн үйлдвэрлэлийг сүү, мах, ноосны чиглэлийн эрчимжсэн мал, гахай, шувууны аж ахуйтай хослон хөгжүүлэх		
	Эхний шатанд олсон амжилтанд тулгуурлан газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлж, тариалан эрхлэгчид хөрөнгө, санхүүгийн хувьд биеэ дааж, хөрөнгө оруулалт хийх боломжтой болно	Сум бүрт 2-оос доошгүй газар тариалан мал аж ахуйг хослон эрхэлж байгаа эрчимжсэн хоршоо, фермерийг байгуулах	Үр тариа, тэжээлийн ургамлын 40-өөс дээш хувийг усалгаатай тариалангаас хураан авч, дотоодын хэрэгцээг бүрэн хангана. Мөн таримал тэжээлийн 40.0%, жимс, ургамлын тосны 5.0-10.0%-ийг дотоодын үйлдвэрлэлээр хангана. Гадаадын зах зээлд экологийн цэвэр бүтээгдэхүүнээр өрсөлдөх боломж бүрдэнэ	2011-2020
		Туслах аж ахуй эрхэлж байгаа өрхийн тоог аймгийн нийт өрхийн 60.0 хувьд хүргэх		
		Арвай, хошуу будаа, шар буурцаг, рапс, эрдэнэшиш зэрэг хүнс тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх, нэр төрлийг олшруулах, тэдгээрийн үр үйлдвэрлэлийг дэмжих		
		Ганд тсвэртэй, богино хугацааны болцтой, ургац ихтэй үрийн сантай болох		
		Аймаг, сумын төвд хүнсний ногоо даршлах, нөөшлөх үйлдвэр цех байгуулах		
2.4 Аж үйлдвэрийн хөгжил				
	Боловсруулах аж үйлдвэрийг сэргээн, техник технологийн шинэчлэл хийж, хүчин чадлыг нь сайжруулах замаар жилийн дундаж өсөлтийг 6-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ	Тэшиг сумын гэрийн модон эдлэлийн үйлдвэрийг сэргээх	Зах зээлд өрсөлдөх чадвар бүхий эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, нэр төрөл нэмэгдэнэ	2006-2010
		Бөөний худалдааны сүлжээнд түшиглэн мах, ноос ноолуур, арьс ширийг стандартын дагуу бэлтгэх, тэдгээрийг дотоодын үйлдвэрүүдтэй хоршин боловсруулах чиглэлийн жижиг дунд үйлдвэр байгуулах, бүтээгдэхүүнийг нь дотоод гадаад зах зээлд борлуулах маркетингийн асуудлыг улсын томоохон үйлдвэрүүдийн эрэлт, хэрэгцээтэй холбон зохистой шийдвэрлэх		
		Модны нөөцийг түшиглэж мод боловсруулах үйлдвэр байгуулж, модны тарьц үржүүлэх аж ахуйн нэгжийг дэмжих		
		Сүү, цагаан идээ боловсруулах орчин үеийн технологи бүхий үйлдвэрийг байгуулах		
		Махны үхрийн загвар аж ахуйг байгуулан мал бордох, мах боловсруулах үйлдвэрийн цогцолбор байгуулна		
		Хог хаягдлыг ялгах, дахин боловсруулах үйлдвэрийг байгуулна		

		Хүнсний үйлдвэрийн чиглэлээр жимс, жимсгэнэ, хүнсний ногоог дахин боловсруулах үйлдвэр байгуулна		
		Орон нутагт гурилын жижиг үйлдвэрүүд байгуулах замаар дотоодын хэрэгцээг хангана		
	Аймгийн эрдэс, түүхий эдийн нөөц, баялгийг эдийн засгийн эргэлтэнд шат дараалан оруулж, уул уурхайн салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ	Нүүрсний орд илэрцүүдийн нарийвчилсан судалгаа, хайгуул хийж, ашиглалт явуулж эхлэнэ. Баяндуурахын нүүрсний уурхайн олборлолтыг нэмэгдүүлнэ	Уул уурхайн олборлох салбарын бүтээгдэхүүний гаргалтыг нэмэгдүүлнэ	2006-2010
		Тэшиг сумын Азарга, Цагаан жалга голын сав газарт геологийн хайгуул хийх, Хөх чулуутын ордын эрэл, үнэлгээний ажлыг дуусгана		
		Тавтын алтны үндсэн ордыг ашиглах уул уурхайн үйлдвэрийг байгуулна		
		Хутаг-Өндөр сумын Хантайн молибден, Сэлэнгийн нүүрс, нутгийн өмнөд хэсэгт бүртгэгдсэн берелли, необий-таталийн илэрцүүдэд хайгуулын ажил хийлгэх, түүнчлэн Гурванбулаг сумын каолий-слюдийн найрлага бүхий шаврын илэрцэд нарийвчилсан эрлийн ба хос судалгаа явуулж эдгээрийг ашиглах үйлдвэр байгуулна		
	Барилга үйлдвэрлэлийн стандартыг хангасан барилгын материалын үйлдвэрлэлийн суурийг бий болгож, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ	Төмөр бетон болон хүрмэн блокийн цех шилэн хөвөнгийн үйлдвэр байгуулах асуудлыг судлаж холбогдох газарт санал тавьж шийдвэрлүүлнэ	Иргэдийн амьдрах таатай орчин бүрдэнэ	2006-2010
		Дөчин мянган орон сууц хөтөлбөрийн хүрээнд Булган аймагт 200 айлын орон сууцыг барина		
		Булган хотын нийтийн эзэмшлийн орон сууцны барилгын дээврийг ээлж дараатай засварлаж сууцны гаднах талбайг тохижуулна		
		Инженерийн хийцтэй цэвэр бохир усны шугаманд холбогдсон амины орон сууцны хороолол байгуулахыг дэмжинэ		
		Гэр хороололд амьдарч байгаа иргэдийн орон сууцны нөхцлийг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ		
2.5 Аялал жуулчлал				
	Байгалийн үзэсгэлэнт газруудыг тэдгээрийн даац боломжид	Түүх соёлын дурсгалт газар, байгалийн үзэсгэлэнт газруудыг аялал жуулчлал, үзмэрийн зориулалтаар бэлтгэнэ	Гадаадын жуулчид, дотоодын аялагчдын тоо нэмэгдэж, аялал жуулчлалын салбарын	2006-2010
		Бүх төрлийн тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэх		

	тулгуурлан зохистой ашиглаж, аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ	Аялал жуулчлалын бүс нутгийн зам гүүрийг тавих, тэмдэгжүүлэх	ДНБ-д эзлэх хувийн жинг ... хувьд хүргэнэ	
		Жуулчдыг хүлээн авах зочид буудал, зоогийн газар, үйлчилгээний газруудын тоог нэмэгдүүлж, стандартын шаардлагад нийцүүлнэ		
		Байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэн аялал жуулчлалын дотоод сүлжээ бий болгон аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд хамрагдана		
		Аймгийн аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөө, түүх соёлын дурсгалт газруудын танилцуулга, статистик мэдээ, эдийн засгийн шинжилгээ судалгаатай болно		
		Үйлчилгээний чанар стандартын шаардлага хангах ажлыг зохион байгуулах		
		Аялал жуулчлалын баазын ажилтнуудыг мэргэшүүлэх, давтан сургах		
2.6 Зам тээврийн хөгжил				
	Мянганы зам төслийг үргэжлүүлэн хэрэгжүүлнэ	Эрдэнэт-Булган-Уньтын авто замыг барьж дуусгах, Уньт-Хутаг-Өндөр-Мөрөнгийн замын ажлыг эхлүүлнэ. Дашинчилэн-Архангайн чиглэлийн хатуу хучилттай замыг үргэжлүүлэн барих	Тээврийн сүлжээ сайжирч, "Мянганы зам" барих ажил эрчимжинэ	2006-2010
		Тэшиг-Закаменьскийн чиглэлийн авто замыг засаж сайжруулна		
		Дашинчилэн-Өгийнуур-Батцэнгэл-Хануйн гүүрийн босоо чиглэлийн авто замыг хайрган хучилттай болгох		
		Орон нутгийн замуудыг сайжруулж зарим голд холимог хийцийн гүүр барих		
		Тээврийн салбарыг эдийн засгийн өсөлт болон нийгмийн хөгжлийг хангах чиглэлд нийцүүлэн хөгжүүлэх		
		Бага Илэнхийн боомтоос Булган хүрэх босоо тэнхлэгийн замыг барьж эхлэх, Булган-Хархорины 210 км замыг барих		
		Зам тээврийн сүлжээ сайжирна	2011-2020	
2.7 Эрчим хүчний салбарын хөгжил				
	Эрчим хүчний хямд, найдвартай эх үүсвэрүүдийг шинээр бий болгоно	Сайхан-Овоогийн нүүрсний уурхайд технологийн шинэчлэл хийж, хүчин чадлыг нь бүрэн ашиглаж, нүүрс олборлолтыг нэмэгдүүлэх, экспортлох, химийн үйлдвэр байгуулах асуудлыг судлаж шийдвэрлэх	Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээг жилд дунджаар ...-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ	2006-2010
		Нүүрс, модыг орлох хий, шингэн түлш зэрэг түлшний эх үүсвэрийн судалгааг шинээр хийж, ашиглаж эхлэх		

		Хөдөөгийн малчин өрх, фермерийн аж ахуй, суурингуудыг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах “Буман нарны гэр” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ		
		Шахмал түлшний үйлдвэр хөгжүүлэх		
		Орхон гол дээр 100 мвт хүртэлх хүчин чадалтай усан цахилгаан станц барьж ашиглалтанд оруулах		2011-2020
2.8 Харилцаа холбооны салбар				
	Мэдээлэл холбооны орчин үеийн үйлчилгээ, хэрэглээг эрчимтэй нэвтрүүлнэ	Аймаг, сумын төвүүдэд мэдээллийн технологийн төвүүд байгуулах	Холбооны үйлчилгээнд тоон системийг бүрэн нэвтрүүлж, холбоо мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болох үндэс суурь тавигдана	2006-2010
		Сумдыг орчин үеийн АТС-ээр хангана		
		Өндөр хурдны агаарын шилэн кабельд холбогдох		
		УБ-Дашинчилэн-БУ, Дашинчилэн-Арвайхээр чиглэлийн дамжуулах сүлжээг шилэн кабелиар шинэчлэх		
		Интернетийн үйлчилгээг сумдад нэвтрүүлэх		
		Хот суурингийн гудамж талбай, албан байгууллага, айл өрхийг хаягжуулж, шуудангийн бүсийн тогтолцоонд шилжүүлэх		
		Сумын төвийн холбооны систем болон аймаг, сумын хооронд дамжуулах системүүдийг тоон сүлжээнд бүрэн нэвтрүүлэх		
		Өндөр хурдны интернетийн үйлчилгээг сумдад нэвтрүүлэх		
		Үүрэн телефон хэрэглэгчдийг нийт хүн амын ,, хувьд хүргэх		2011-2020
2.9 Санхүүгийн секторын хөгжил				
	Салбарын хүрээнд шинжлэх ухааны ололтыг өргөн ашиглаж газар тариалан, мал аж ахуйг хослон эрчимжүүлэн хөгжүүлэх, дотоодын хэрэгцээг бүрэн хангаж улсын хэрэгцээнд тодорхой хувь нэмэр оруулах	Үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого барьж, зээлийн хүүг үе шаттайгаар бууруулна	Арилжааны банкуудаас олгох зээлийн хүүгийн хэмжээ жилд 12% болно	
		Арилжааны даатгалын компаниудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагад учирч болох эрсдлийг бууруулах, даатгалын ач холбогдлыг сурталчлах ажлыг өргөжүүлэх	Арилжааны даатгалын компаниудын өрсөлдөх чадвар нэмэгдэж, даатгалын төрөл, хамрах хүрээ өргөжнө	
ГУРАВ. НИЙГМИЙН ХӨГЖИЛ				

		3.1 Хүн амын өсөлт, хүний хөгжлийг хангах талаар		
	Хүн амын өсөлтийг дэмжиж, хүний хөгжлийн түвшинг дээшлүүлэх	Аймаг, сумын түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтөнд хүн амын хүчин зүйлсийг оновчтой тусган хэрэгжүүлэх арга механизмыг бий болгож нэвтрүүлэх	Хүн амын жилийн дундаж өсөлт 1.5 хувиас доошгүй байна	2006-2010
		Аймгийн эдийн засгийн жилийн дундаж өсөлтийг 10 хувьд хүргэж ажлын байрны хангамжийг сайжруулах замаар хүн амын гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг сааруулах		
		Хүний амьдралын нийгэм, эдийн засаг, орчин ахуйн таатай нөхцлийг бүрдүүлэх замаар 2010 он гэхэд бүсийн хүн амын дундаж наслалтыг 66-д хүргэх		
	Хүн ажиллаж амьдрах таатай нөхцөл бүрдүүлж, хүний хөгжлийг бүх талаар хурдасгана	Хүн ажиллаж амьдрах нийгэм, эдийн засаг, орчин ахуйн таатай нөхцлийг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх	Аймгийн хүн ам уугуул нутагтаа тогтвор суурьшилтай ажиллаж амьдрах нөхцөл бүрдэнэ	2011-2020
3.2 Хүн амын ядуурал, ажилгүйдлийг бууруулах талаар				
	Ядуурлаас гарах оновчтой арга зам боловсруулж хэрэгжүүлэх	Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр, Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангахад туслан ажиллах	Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн тоог 2 дахин бууруулах	2006-2010
		Нийгмийн эмзэг хэсгийн хүн амд зориулан ядууралтай тэмцэх, иргэний боловсрол олгох “төв” байгуулж бүлэг, хамт олон, өрхөд түшиглэсэн сургалт явуулах, тэдгээрт зориулан ажлын шинэ байр бий болгосон ажил олгогч төсөл хэрэгжүүлэгч нарыг дэмжих		
		Хөдөөд өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх		
	Ядуурлыг арилгах арга механизмыг хэрэгжүүлнэ	Ядуурлыг бууруулах чиглэлээр олгож буй жижиг зээлд хамрагдагсдыг заавал үйлдвэрлэл үйлчилгээний сургалтанд хамруулах арга хэмжээ авах	Мянганы хөгжлийн зорилтын дагуу амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн тоог хүн амын 10 хүрэхгүй хувьд байлгана.	2011-2020
		Ядуурлын эсрэг ядуу хүн өөрөө тэмцдэг, түүнд нь төрийн болон төрийн бус байгууллагууд тусалдаг үзэл төлөвлөлийг нийгэмд тогтоох сургалт, сурталчилгаа явуулах		
		Ажлын байрны тоог нэмэгдүүлэх, орон нутгийн зах зээлийг өргөтгөх, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх		

		Ажлын дадлага, ур чадвар олгох богино хугацааны сургалт зохион байгуулж жил бүр 400-аас доошгүй иргэдийг хамруулан мэргэжлийн чадварыг дээшлүүлэх		
		Хялганат, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр суманд мэргэжлийн түр сургалтын төв байгуулж, МСҮТ-ийг загвар сургууль болгон тохижуулж сургалт зохион байгуулах		
		Нийтийг хамарсан ажилд хөдөлмөр эрхлээгүй залуучууд, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг өргөн хамруулах замаар ажлын байрыг нэмэгдүүлэх		
		Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг боловсронгуй болгож мэдээлэл, жуучлалын нэгдсэн сүлжээг бий болгох		
		Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ, хоршоо, нөхөрлөл, өрхийн болон фермерийн аж ахуй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар ажлын байр бий болгох		
	Аймгийн хүн амыг тогтвортой ажлын байраар хангах орлогын байнгын эх үүсвэрийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг тогтвортой бууруулна	“Эрдэнэт-Булган-Уньтын чиглэлийн зам, “Ногоон хэрэм”, 40 мянган айлын орон сууц төслүүдийн хүрээнд төв орон нутгийн Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний хэлтсүүдээр зуучлуулан ажлын түр болон байнгын байраар хангах ажлыг зохион байгуулах	Аймгийн хэмжээгээр жилд дунджаар 850-900 ажлын байр шинээр бий болгож, ажилгүйдлийн түвшинг 4.9 хувиас хэтрүүлэхгүй	2006-2010
Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй зам гүүр, давааг байнга засаж сайжруулах, арчилгаа хийх замаар ажлын байр бий болгох				
Байгалийн баялаг ашиглах, байгаль хамгаалах чиглэлийн жижиг бизнесийн үйл ажиллагааг дэмжих				
	Хөдөөгийн хүн амыг орлогын найдвартай эх үүсвэртэй болгож ажлын байрны тоог нэмэгдүүлнэ	Мал аж ахуй, газар тариалан, хадлан, тэжээл бэлтгэх болон бусад чиглэлэр хоршоо, нөхөрлөл байгуулах замаар албан бус хэвшлийг хөгжүүлэх, улмаар албан ёсны хэвшилд аажмаар хандуулах	Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжиж, орлого нэмэгдэнэ	2006-2010
Өрхийн үр тариа, төмс хүнсий ногоо, жимс жимсгэнэ тарих гахай тахиа үржүүлэх зэргээр туслах аж ахуй эрхлэхэд хамруулах ажлыг сум бүрт тодорхой төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэх				
Сум, багийн төвд халуун ус, үсчин, оёдол, гутал засвар зэрэг ахуй үйлчилгээний цэг, салбар нээн ажиллуулах явуулын үйлчилгээ бий болгоход туслах замаар хөдөө дэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих				

		Ойн нөөц, усны эх булаг, ховордсон ан амьтдыг хамгаалах, ойг нөхөн сэргээх, ой цэвэрлэх, худаг, булаг шандыг тохижуулах ажилд орон нутгийн иргэдийг өргөн хамруулж, түр болон байнгын ажлын байраар хангах, байгалийн баялгыг ашиглах чиглэлээр үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэн зохион байгуулах		
		Байгаль орчныг хамгаалах, ялангуяа говь, хээр нутгийг цөлжилтөөс сэргийлэх, ойн зурвас байгуулах замаар газрын хөрс, бэлчээрийг хамгаалах ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэдийг оролцуулах ажлыг зохион байгуулах		
		Хоршоо нөхөрлөл, фермерийн аж ахуй эрхлэх маркетинг, менежментийн талаар сургалтууд зохион байгуулах, хадгаламж, зээл үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоод байгуулах санаачлагыг дэмжих		
	Бүсийн хүн амыг ажлын байраар хангах асуудлыг бүрэн шийдвэрлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ	Хөдөлмөрийн зах зээлийн, эрэлт нийлүүлэлттэй уялдуулан ажилгүй иргэн, ажил хайгчдыг сул чөлөөтэй ажлын байранд зуучлах үйл ажиллагааг хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсээр дамжуулан зохион байгуулах	Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн тогтолцоо бүрэлдэж, ажилгүйдлийн түвшинг ... хувиас хэтрүүлэхгүй байлгана	2011-2020
		Орон нутгийн хөдөлмөрийн асуудал хариуцсан ажилтан түүний чадавхийг бэхжүүлэх бүтэц зохион байгуулалтыг сайжруулах, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, сурталчилгааны ажлыг өргөтгөн сайжруулах		
		Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын материаллаг бааз, сурах орчин, хөтөлбөрийг шинэчлэн сайжруулж ерөнхий боловсролын бүрэн ба бүрэн бус дунд төгсөх ангийн сурагчид, оюутныг хамруулах		
		Ажилгүйдлын даатгалд хамрагдаагүй, удаан хугацаагаар ажилгүй байгаа, нийгмийн эмзэг бүлгийн иргэд, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэд болон тухай онд ЕБС төгссөн ажил, сургуульгүй үлдсэн хүүхдүүдийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжил олгох болон мэргэшлийн ур чадварын сургалтанд бүрэн хамруулах арга хэмжээг авах		
		Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангасан ажлын байрны нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээ авах		

		Хөдөлмөр эрхлээгүй иргэд болон албан бус хэвшилд ажиллагсдын хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сүлжээнд бүрэн хамруулах		
		Албан бус хэвшилд ажиллагсдын мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөрийг ажил олгогч, ажилчдын төлөөллийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх		
		3.3 Хүн амын боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх талаар		
	Сургалтын болон соёлын байгууллагын бүтэц хэв шинж, зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгох, боловсон хүчний чадавхийг дээшлүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулах	Орон нутгийн онцлогт тохируулан бага, суурь, бүрэн дунд сургуулийн уян хатан бүтэц бий болгох	Бүтэц зохион байгуулалтын оновчтой тогтолцоо бүрдэж, сургалтын орчин сайжирч үйлчилгээний чанарт ахиц гарна	2006-2010
		Сургууль, сургуулийн гаднах сургалтын залгамж холбоог бэхжүүлэх		
		Эцэг эх, байгууллага, олон нийтэд түшиглэсэн сургуулийн өмнөх боловсролын олон хувилбарт сургалтыг дэмжих		
		Сургууль, соёлын байгууллагад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх		
		Сургуулийн зөвлөлийн үйл ажиллагааг хэвшүүлэх		
		Багш нарын мэргэжлийг дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх		
		Сургалтын техник хэрэгсэл, лабораторийн хүрэлцээг нэмэгдүүлэх		
		Соёл, урлагийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх		
		Бичиг үсэг үл мэдэх явдлыг багасгах		
	Соёл, боловсролын үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэн сургалтын ээлтэй орчин бүрдүүлэх	Бүх нийтийн боловсролын ерөнхий түвшинг дээшлүүлэх	Технологийн дэвшил салбарын хэмжээнд бүрэн нэвтэрч, үйлчилгээнд бүх нийтийг хамруулах нөхцөл бүрдэнэ	2011-2020
		Сургуулийн гадна байгаа хүүхдүүдэд боловсрол нөхөн олгох бүх хэлбэрийг дэмжинэ.		
		Эмзэг бүлгийн өрхийн хүүхдийн сурах боломжийг нэмэгдүүлэх		
		Ерөнхий боловсролын хүрээнд мэргэжлийн анхан шатны боловсрол олгох ажлыг зохион байгуулна.		
		Музейг эрдэм шинжилгээ, судалга арга зүйн төв болгох		
		Соёлын байгууллагуудад технологийн нэвтрүүлэх		
		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд хамруулах		
		3.4 Хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар		
	Аймгийн эрүүл мэндийн бодлогыг тодорхойлж, эрүүл	Аймгийн эрүүл мэндийн салбарын бүтэц тогтолцоог боловсронгуй болгож, улсын болон хувийн хэвшлийн эмнэлгийн оношлогоо эмчилгээний чадавхийг сайжруулах	Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн суурь тусламж, үйлчилгээний хүртээмж,	2006-2010

	<p>мэндийн байгууллагын тогтвортой хөгжлийг ханган, сум өрхийн эмнэлгийг бэхжүүлнэ</p>	<p>Сумдын болон өрхийн эмнэлгийн материаллаг бааз, оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулж, мэс засал, шүд, хүүхэд зэрэг зарим нарийн мэргэжлийн үйлчилгээг өргөтгөх</p>	<p>чанар дээшилнэ</p>		
		<p>Сумдын эмнэлгийг компьютержүүлж, нэгдсэн сүлжээнд холбон, мэдээ мэдээллийн чанар хүртээмжийг сайжруулах</p>			
		<p>Олон улсын түвшинд нийцэж хөрвөн ажиллах чадавхи бүхий өндөр мэдлэг, ур чадвартай сувилагч, мэргэжилтэнг бэлтгэх, эмнэлгийн боловсон хүчний мэргэжлийг дээшлүүлжорчин үеийн тоног төхөөрөмжийг эзэмшүүлэх</p>			
		<p>Хүн эмнэлгийн болон эхчүүдийн амрах байруудыг шинээр барих, заримыг нь засварлан тохижуулах ажлыг үе шаттай зохион байгуулах</p>			
		<p>Сум, баг, өрхийн эмнэлэг, эмчийг дуудлагын машин унаагаар хангаж, эмийн нөөцийг нэмэгдүүлэх, зөөлөн эдлэлээр хангах ажлыг дэс дараатай зохион байгуулах</p>			
		<p>Өвчлөл, жирэмсний хүндрэлийг эрт илрүүлэх, оношлуурын сүүлийн үеийн арга технологийг аймаг, сумын түвшинд нэвтрүүлж, эмзэг бүлгийнхний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эх хүүхдийн зохистой хооллолтын талаар сургалт явуулах, 5 хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн хангамж чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх</p>			
		<p>Бохир усны сүлжээ, татуурга, цооног, бие засах газрын стандарт, эрүүл ахуйн хэм хэмжээг хангаж, хот суурин газрын цэвэрлэх байгууламжийн техник, технологийг сайжруулах</p>			
		<p>Хүнсний болон эмийн аюулгүй байдлыг хангах стандартуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах</p>			
		<p>Сэлэнгэ, Бугат, Хангал сумдын залгаа багийн яаралтай дуудлагыг Орхон аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүлээн авдаг болгох, Бугат, Орхон сумдын хил залгаа багуудад аймгийн нэгдсэн эмнэлэг тусламж үйлчилгээ үзүүлэх зохицуулалтыг хийх</p>			
		<p>Орон нутаг дахь зарим рашааныг түшиглэн нөхөн сэргээх эмчилгээ, рашаан сувиллын газар байгуулах</p>			

		Ундны усны хатуулаг, эрдэсжилт ихтэй зарим сумын төв, суурин газруудад ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах ажлыг зохион байгуулж, хүн амын ундны усны чанарыг сайжруулах		
	Зонхилон тохиолдох өвчин эмгэгийг оношлох, эмчлэх нөхцлийг бүрдүүлэх замаар хүн амын өвчлөл, эндэгдлийг бууруулна	Эх нялхсын эрүүл мэндэд онцгой анхаарч, “Мянганы тунхалал”-д нийцүүлэн эх нялхсын эндэгдлийг бууруулна	Зонхилон тохиолдох өвчин эмгэгийг оношлох, эмчлэх нөхцөл бүрдэж улмаар хүн амын өвчлөл, эндэгдэл буурна	2006-2010
		Дархлаажуулалтанд хавсарсан (5-т вакцинжуулалт) вакцинжуулалтыг нэвтрүүлнэ		
		Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, ялангуяа аймгийн хэмжээнд буурахгүй байгаа сүрьеэ, халдварт шар, бэлгийн замын халдварт өвчнийг одоогийн түвшнээс 20 хувиар бууруулах арга хэмжээ авна		
		Олон улсын хөл хориот өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүн амыг хамгаалахад чиглэсэн оношлогоо эмчилгээний аргуудыг зохион байгуулж чадавхийг сайжруулна		
		Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эм тариа, вакцины нөөцийг зохих түвшинд бүрдүүлж хамгаалалтын хувцасны хангалтыг нэмэгдүүлнэ		
		Дархлаажуулалтанд хавсарсан вакцин нэвтрүүлэх замаар эрүүл хүүхдэд хийх тарилгын тоог цөөрүүлнэ		
		Зүрх судасны өвчин, хорт хавдар, ослоос шалтгаалсан нас баралтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ		
		Хүүхдийн дунд зонхилон тохиолдож буй өвчний оношлогоо эмчилгээг сайжруулан эмч нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх замаар хүүхдийн өвчлөлийг багасгаж, нялхсын болон хүүхдийн эндэгдлийг 50 хүртэл хувиар бууруулах ХӨЦМ-ийн тандалтыг сайжруулна		
	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг	Хүн амд эмнэлгийн болон НЭМ-ийн тусламж үйлчилгээг шуурхай хүргэх тогтолцоог боловсронгуй болгох. Хөдөөгийн түргэн тусламжийн үйлчилгээний шуурхай байдлыг хангах арга хэмжээ авна	Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, амьдрах, ажиллах, суралцах эрүүл ахуйн таатай	2011-2020

	сайжруулж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ	Сувилахуйн болон тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээний менежментийг боловсронгуй болгох, сувилгааны албыг бэхжүүлэн чадавхижуулах замаар сувилахуйн болон тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	орчин бүрдэнэ	
		Хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл аж төрөх ёсны мэдлэг олгох сургалтыг чанаржуулж хандлагыг өөрчлөнө		
		Эрүүл мэндийг дэмжигч хамт олон болох иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэл санаачлагыг бүх талаар дэмжиж ЭМД байгууллагын тоог нэмэгдүүлэх		
		Гэр бүл төлөвлөх, эмэгтэйчүүдийн эсэн мэнд амаржих, өсвөр үеийг бэлгийн амьдралд бэлтгэх зэрэг НҮЭМ-ийн тусламж үйлчилгээний стандартыг хангах		
		Хүн амыг стандарт, эрүүл ахуйн хэм хэмжээнд тохирсон унд, ахуйн усаар найдвартай хангах, усны эх булгийг бохирдлоос хамгаалах нөхцлийг бүрдүүлэх		
		Хувийн эмнэлгийн үйл ажиллагааг дэмжиж өргөжүүлэх		
		Аймгийн төв болон сумын төвүүдэд бие бялдрыг чийрэгжүүлэх бялдаржуулах төвүүдийг байгуулан үйл ажиллагааг дэмжих		
		Булган аймгийн НЭ-ийг түшиглэн “Геронтологи-Сэргээн засалтын төв” байгуулах		
		Өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх талаар орчин үеийн дэвшилтэт арга ажиллагааг нэвтрүүлэн дундаж наслалтыг уртасгаж хүн амын эрүүл мэндийг сайжруулна		
	нийт халдварт өвчин болон бэлгийн замаар дамжих халдварыг бууруулах			
	эхийн эндэгдлийг бууруулах стратеги, НҮЭМ-ийн үндэсний хөтөлбөрийг тууштай хэрэгжүүлснээр эхийн эндэгдэл гаргахгүй ажиллах			
	Зарим сумдад оношлогоо сувилгааны төв байгуулан хөдөөгийн иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх			

		Оношлогоо эмчилгээний чадавхийг дээшлүүлэх, мэдээллийн технологийн дэвшлийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх		
ДӨРӨВ. БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ				
4.1 Цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх				
	Хүний сөрөг үйл ажиллагааны нөлөөгөөр явагдаж байгаа цөлжилтийн шалтгаан, үр дагаврыг таслан зогсоож, цөлжилтөөс урьдчилан сэргийлнэ	цөлжилттэй тэмцэх конвенци, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Хүний үйл ажиллагааны улмаас цөлжиж байгаа үйл ажиллагааг зогсоосны дүнд цөлжилтийн хүрээ багасна	2006-2020
		цөлжилтэй тэмцэх төслийг цөлжилтөд нэрвэгдэж байгаа нутгийг хамруулан боловсруулж, шат дараалан хэрэгжүүлэх		
		цөлжилтийн шалтгаан, явц, цаашдын хандлагад үнэлгээ өгч, хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд учрах сөрөг үр дагаврыг тогтоох судалгаа явуулах		
		ган, цөлжилтийн явц, орчны өөрчлөлтийг хянах хяналт-шинжилгээний тогтолцоог бүрдүүлэх		
		цөлжилтийн мэдээллийн сан бүрдүүлж, улс болон олон улсын сүлжээнд хамрагдах арга хэмжээ авах		
		сумдын бэлчээрийн ургац, даац, багтаамжийг тодорхойлон, бэлчээр ашиглалтын зохистой системийг туршин нэвтрүүлэх		
		бэлчээр ашиглалт, тариалангийн зохион байгуулалт болон газрын менежментийг боловсронгуй болгож, газар зохион байгуулалтыг сайжруулах		
		хээрийн бүсийг усжуулах, цас, борооны усыг тогтоох бйгууламж барих		
		авто замыг журамлах, сайжруулсан, хатуу хучилттай замыг нэмэгдүүлэх		
		газар тариаланд хөрс хамгаалах ойн зурвасыг байгуулах		
		ахин ашиглах боломжгүй тариалангийн атаршсан талбайг нөхөн сэргээж, олон наст ургамал тарьж бэлчээрийн ангилалд шилжүүлэх		
		төв, суурин, түүний орчимд цөлжилтийн нөхцөл бий болохоос сэргийлж, хамгаалалтын болон ногоон бүс байгуулах		

		геологи хайгуул, уул уурхайн үйлдвэрлэлийн явцад байгаль орчинд учруулсан сөрөг нөлөөллийг арилгах, нөхөн сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлэх		
		цөлжилттэй тэмцэх арга хэмжээг ядуурлыг бууруулах, ажлын байр бий болгох, хүн амын амжиргааны түвшинг дээшлүүлэх үйл ажиллагаатай нягт уялдуулан зохицуулах		
	Цөлжсөн газрыг нөхөн сэргээх ажлыг далайцтай зохион байгуулна	цөлжсөн нутагт мод сөөгний байгалийн сэргэн ургалтыг тэтгэх, тарих ажлыг эрчимжүүлэх, мод үржүүлэх, ойжуулах ажлын цар хүрээг эрс нэмэгдүүлэх	Цөлжилтийн үйл ажиллагааг зогсоож, цөлжсөн газрыг сэргээх үндсийг тавина	2011-2020
		гандуу, хуурай нөхцөлд дасан зохицсон мод сөөгний тарьц, суулгацаар орон нутгийн хэрэгцээг хангах		
		хөрсний элэгдэл, эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээх эрчимтэй технологи боловсруулж хэрэгжүүлэх		
		сул элстэй газруудад элс тогтоогч ургамлуудлыг тарьж ургуулан, ургамлан нөмрөг бий болгох		
		жимсний цэцэрлэг, плантаци байгуулах		
		урд сумдуудад таримал улиас, хайлаасан ой бий болгох		
4.2 Улсын тусгай хамгаалалттай газар нутаг				
	Аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөн, хамгаалалтыг сайжруулна	Экологийн тэнцлийг хангахад чухал ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлтэй газар нутгийг улс, аймаг, сумын тусгай хамгаалалт, нөөцөд хамруулж, экологийн хувьд тогтвортой, эдийн засгийн хувьд ашигтай газар ашиглалтын бодлогыг нутаг дэвсгэрийн онцлог, нийгэм, эдийн засгийн хөгжилтэй уялдуулан хэрэгжүүлэх	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 8 хувьд хүргэнэ	2006-2010
		Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн хөгжлийн горим, зүй тогтлыг танин мэдэх, байгалийн нөөц, баялгийг үнэлж тодорхойлох, зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх суурь хийгээд хавсарга судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх		
		Тусгай хамгаалалттай газар нутаг дахь ховор ан амьтан, ургамлын судалгаа хийж хэвийн өсөлтийг хангах		

		Тусгай хамгаалалттай газар нутгийг дэлхийн нийтийн жишигт нийцүүлэн хамгаалах, хөгжүүлэх арга хэмжээ авах		
		Экологийн давтагдашгүй онцлог, ач холбогдлоороо ялгарах зарим нутгийг олон улсын шим мандлын нөөц газар болгон дэлхийн өвийн сүлжээнд хамруулж дэлхийн шим мандлын хамгаалалттай бүс нутаг болгох үндэслэлийг боловсруулах		
	Аймгийн өвөрмөц нөхцөл, байгаль орчныг хамгаалах шаардлага, зах зээлийн эдийн засгийн онцлогт тохируулан тусгай хамгаалалттай газар нутгийн цогцолборыг бүрдүүлэн хөгжүүлнэ	Тусгай хамгаалалттай газарт судалгааны төв, бааз, судлаачидтай болж, дэлхийн түвшинд хүрсэн судалгаа шинжилгээ явуулах	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 15 хувьд хүргэнэ	2011-2020
		Тусгай хамгаалалттай газар нутгийг түшиглэн сургалт, сурталчилгаа явуулах, иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил олгох төвүүдийг байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах		
		Амьтан, ургамлын төрөл зүйлийг хамгаалах менежментийг боловсронгуй болгох		
4.3 Ойн нөөцийн ашиглалт, хамгаалал				
	Ойн нөөцийг хамгаалах цогцолбор арга хэмжээ авч нөхөн сэргээлтийг эрчимжүүлж, ашиглалтад тавих хяналтыг хүчтэй болгоно	ойн сангийн мэдээллийг сум, багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гаргасан нарийвчилсан сүлжээг бий болгох	Ойн нөөцийн хамгаалалт сайжирч, зөвшөөрөлгүйгээр огтолж ашиглах явдлыг зогсоож, ойжуулалт, нөхөн сэргээлтийг ашигласан талбайн хэмжээнд хүргэнэ	2006-2010
		сумдыг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх мэргэжилтэй боловсон хүчин, тоног төхөөрөмжөөр хангах		
		аймгийн ойн сангийн бүртгэл, тооллого явуулж, мэдээллийн сан, мониторингийн сүлжээ байгуулах		
		ойн түймрээс урьчилан сэргийлэх, сурталчилгаа, харуул хяналтыг тогтмол явуулах, сургалтын төвүүд байгуулах, түймэр унтраах ажилд мэргэжлийн хүмүүс бэлтгэх, багаж хэрэгслээр тасралтгүй хангах арга хэмжээ авах		
		ойн түймрээс хамгаалах зурвасыг технологийн дагуу ойн нөөц ихтэй газарт хийх		
		ойн хортон шавьжтай тэмцэх ажлыг технологийн горимын дагуу зохион байгуулах		

	ойн модны зонхилох хортон шавьжийн хөнөөлийн голомтуудыг илрүүлж, тархахаас нь өмнө устгах, ойн хөнөөлт шавьжтай тэмцэх ажилд шаардлагатай бактерийн бэлдмэл үйлдвэрлэх цех байгуулах	
	мод бэлтгэсэн болон ойн түймэр, хөнөөлт шавьжинд нэрвэгдсэн талбайд нарийвчилсан судалгаа явуулсны үндсэн дээр ой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг тухай бүрт нь шуурхай боловсруулж ажиллах	
	мод сөөгний үр, боргоцой бэлтгэх, тарьц суулгац ургуулах цехийг байгуулах	
	шилмүүст мод үржүүлгийн хүлэмж, ойн питомникийг голын хөндий, ойн сан бүхий газруудыг түшиглэн байгуулах. Үүнд мод их хэмжээгээр бэлтгэж буй сумдыг хамруулах	
	ойжуулалт хийх, үр бэлтгэх, ойжуулсан талбайг хамгаалах ажлыг мэргэжлийн байгууллагын удирдлага, хяналтад нутгийн иргэдийн хүчээр хийж, нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, элсний нүүлт, цөлжилтөөс хамгаалах арга хэмжээ авах	
	түлшинд нойтон мод огтолж хэрэглэхийг бүрмөсөн зогсоох, ой бүхий сумдын арчилгаа, цэвэрлэгээний огтлолтоос гарсан модыг хямд үнээр олгож, орон нутгийн нүүрсний ордыг түлшний модтой зөв зохистой хослуулан ашиглах	
	хүн амын ахуйн орчин нөхцлийг сайжруулах, хүнсний хэрэгцээнд зориулан бургас, улиас, улиангар, чацаргана, үхрийн нүд зэрэг мод, сөөг, жимсний модыг үйлдвэрийн аргаар үржүүлэх	
	ойн хортон шавьж, өвчинтэй биологийн болон байгальд хоргүй аргаар тэмцэх ажлыг өргөжүүлэх	
	“Ногоон хэрэм” хөтөлбөрийг аймгийн хөгжлийн зорилт, арга хэмжээтэй холбон гадаадын байгууллагуутай хамтран хэрэгжүүлэх	
	ургаа мод огтлохыг хязгаарлах хориг арга хэмжээ авах	
	ихээр сүйдэж байгаа хус модыг бэлтгэхийг хориглох	
	нутаг орноо ойжуулах, хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	

		хот, суурин газрын орчмыг ойжуулах, цэцэрлэгжүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх		
		гол горхины сав газар болон булаг, шандны эхийг ойжуулж хамгаалах		
	Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах зохистой бүтцийг бүрдүүлж, үйл ажиллагааны оновчтой, дэвшилтэт менежмент, технологид шилжүүлнэ	тарьц, үрээр хангадаг, мэргэжлийн удирдлагаар хангаж зөвлөгөө өгдөг мод үржүүлэг, ойн судалгааны төвийг аймгийн төвд байгуулах	Ойг хамгаалах, нөхөн сэргээх ажилд дэвшилтэд менежмент, технологи нэвтэрч, ойтой талбайн хэмжээг жилд дунджаар 1 хувиар нэмэгдүүлнэ	2006-2010
		хүн амын ахуйн орчин нөхцлийг сайжруулах, хүнсний хэрэгцээнд зориулан бургас, улиас, улиангар, чацаргана, үхрийн нүд зэрэг мод, сөөг, жимсний модыг үйлдвэрийн аргаар үржүүлэх плантацуудыг байгуулах		
		гол горхины сав газар болон булаг, шандны эхийг ойжуулж хамгаалах		
		ойн хөнөөлт шавьжийн зүйлийн нарийвчилсан судалгааг тогтмол явуулсны үндсэн дээр урьчилан сэргийлэх арга хэмжээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх		
		ойн санг гэрээгээр эзэмшүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бий болгох		
		мод боловсруулах үйлдвэрүүдэд хаягдалгүй технологи нэвтрүүлж, эцсийн бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх, ойг хамгаалах, цэвэрлэх, нөхөн сэргээх ажилтай уялдуулан зохион байгуулах		
		ойн дагалдах баялаг, хусны нүүрс ашиглах, ойн химийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, модны давирхайнаас канифол, скипидар ялган авах үйлдвэр байгуулах		
		“Ногоон хэрэм” хөтөлбөрийг гадаадын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх		
		бартаажилт ихтэй ой тайгаас байгаль хамгаалах шаардлагын дагуу мод бэлтгэж, бүтээгдэхүүнээ дотоодын зах зээл дээр борлуулж буй аж ахуйн нэгжид зохих хөнгөлөлт үзүүлэх		
		үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглээний мод бэлтгэсэн байгууллага, иргэдээр огтолсон модны оронд 3-5 мод тариулж хэвшүүлэх		
		ойн нөөц ашигласан төлбөрийн 70 хүртэл хувийг ойг тарьж ургуулах, ойг хамгаалах арга хэмжээнд зориулдаг эрх зүйн орчинг бүрдүүлэх		

		хамтын эзэмшлийн ой байгуулах, ойжуулах, ойн хортон шавьж устгах арга хэмжээнд олон нийтийг төслөөр дэмжин хэрэгжүүлэх		
4.4 Усны нөөцийн ашиглалт хамгаалал				
		аймгийн усны бодлогын менежмент, бүтэц зохион байгуулалтыг сайжруулах		
		газрын гадаргуугийн ус, уст цэгийн үзлэг тооллого явуулж, усан хангамжийн түвшинг шинэчлэн тогтоох		
		усны хими, физик, биологийн судалгаа явуулж, геохими, гидрохимийн зураг зохиох, чанарын үнэлгээ өгөх, усны нөөц, чанарын шалгуур тогтоох		
		ус ашиглалтыг тоолууржуулах		
		төв, суурин газрын ундны усны эх үүсвэрийн ажиллагааг найдваржуулах, иоджуулах, цэнгэгжүүлэх, эрдэсжилтийг багасгах		
		хүн ам олонтой хот, сууринд усыг цэвэршүүлэн, дахин ашиглах технологи нэвтрүүлэх		
		хүн амын ундны усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх бага оврын төхөөрөмжийг урд сумдад нэвтрүүлж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усны хэрэглээг нэмэгдүүлэх		
		бэлчээрийг усжуулах зорилгоор шинээр худаг барих, хуучин худаг цооног засаж сэлбэх ажлыг эрчимжүүлэх. Уст цэгийн техник, технологийг шинэчлэн хямд төсөр ус өргөгчийг үйлдвэрлэх, уламжлалт аргаар худаг гаргах, усыг хамгаалах, лайдах ажлыг зохион байгуулах		
	Аймгийн усны нөөцийг оновчтой ашиглаж, хамгаалалтыг нь сайжруулна	эдэлгээний чанар сайтай насосыг гадаад орноос авах, худагт пластмассан болон зэвэрдэггүй материалаар хийсэн шүүр суулгах асуудлыг шийдвэрлэх	Аймгийн усны нөөцийг оновчтой ашиглах, хамгаалах боломж нөхцөл бүрдэж, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангана	2006-2010
		аймаг, бүсийн усны ашиглалт хамгаалалтын нэгдсэн сүлжээтэй болох		

		рашааны нөөц, химийн найрлага, чанарыг тогтоох, түүний өөрчлөлтийг илрүүлэх судалгааны ажлууд явуулах болон хүний бие организмд ашигтай рашаан болон цэнгэг усыг савлаж зах зээлд нийлүүлэх		
		алт болон бусад ашигт малтмал олборлох явцад алдагдсан усыг нөхөн сэргээх үйл ажиллагааг эрчимжүүлэх, гольдирлыг нь өөрчилсөн гол, горхийг буцаан хуучин гольдиролд нь оруулах ажлыг зураг төслийн дагуу гүйцэтгэх ажлыг эхлүүлэх		
		гол мөрний сав газрыг хамгаалах, хэрэглээг зохистой болгох, гадаргын ус ашиглалтыг нэмэгдүүлэх, гүний хайгуулын ажлыг өргөтгөх төслүүдийг гадаадын хөрөнгө оруулалттайгаар хэрэгжүүлэх		
		гол мөрний сав газрын зөвлөлийг байгуулж ажиллах		
		үйлдвэр, уурхайд усыг эргүүлэн ашиглах, цэвэршүүлсний дараа урсгал усанд нийлүүлдэг болгоход тавих төр, олон нийтийн хяналтыг хүчтэй болгох		
		усны эх үүсвэрийг хамгаалах уламжлалт арга, зан үйлийг сэргээн хөгжүүлэх		
		Булаг, шандны эхийг хашиж хамгаалан хүн амын ундны ус, мал услах цэгийг зааглан зохион байгуулах		
	Бүс нутгийн усны зохистой хэрэглээг хангаж, усны нөөцийг нэмэгдүүлж, бохирдлыг багасгах үр дүнтэй хөшүүргүүдийг нэвтрүүлнэ	усны нөөцийг нэмэгдүүлэх судалгаа, туршилтын ажлыг эрчимжүүлэх	Усны эх үүсвэрүүд, ай савыг бохирдлоос бүрэн хамгаалж, цэвэрлэх байгууламжид шинэ техник, технологи нэвтрүүлснээр усыг 100 хувь цэвэршүүлдэг болж, ундны усны чанар дээшилнэ. Усны нөөцийн шинэ эх үүсвэрүүд бий болж, ашиглалт сайжирна	2011-2020
		усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг томоохон голуудын сав газраар боловсруулж, хэрэгжүүлэх		
		хот, суурин газрын ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлж дуусгах		
		хот, суурин газарт ус ашиглалтыг бүрэн тоолууржуулах		
		Сэлэнгэ, Орхон голын ай сав газрын усны бохирдолтын байдалд үнэлгээ хийлгэж, цаашид энэ бүсийн усны бохирдлыг зогсоох арга хэмжээ авах		
		Зүүнтүрүү, Ачуут, Дундат, Балиг, Баян, Үнэгт цагаан гол болон бусад жижиг голын урсацыг нэмэгдүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлэх		
		усны чанар найрлагыг тодорхойлдог нүүдлийн лабораторитой болох		

		Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрийн орчин болон уул уурхайн ашиглалтаас эвдэрсэн газарт экологийн хиймэл нуур тогтоож загас үржүүлэх, хөрсжүүлэх, ойжуулах ажлыг хэрэгжүүлэх		
		хүн амын ундны усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх ажлыг бүрэн хэрэгжүүлэх		
		усны шинэ нөөцүүдийг илрүүлэн ашиглахад гадаадын хөрнгө оруулалтыг өргөн ашиглах		
		томоохон усан сан байгуулах, бороо, цасны усыг ашиглах төслүүдийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалттайгаар хэрэгжүүлэх		
		зарим гол мөрний усыг хуримтлуулах цогцолборыг барьж байгуулах замаар гадаргын усны нөөц, усан хангамжийг нэмэгдүүлэх		
4.5 Агаар мандлын ашиглалт, хамгаалал				
		агаарын чанарын хяналт-шинжилгээ хийдэг лаборатори байгуулж, шаардлагатай багаж, техник хэрэгслээр хангах		
		гэр, байшинд өргөн хэрэглэгдэж буй энгийн пийшин, зуухны бүтцийг боловсронгуй болгож, түлшний шаталтыг сайжруулах		
		нүүрсний чанарт тохирсон техник, технологийн шинэчлэлтийг шат дараалан хийсний үндсэн дээр халаалтын зуухнууд зэрэг суурин эх үүсвэрүүдийн агаарт гаргах бохирдлын хэмжээг бууруулах		
		уулын байжуулах Эрдэнэт үйлдвэр болон бусад үйлдвэрүүдээс гарах агаар бохирдуулагчийн хэмжээ, бүтцийг тогтоож, техник, технологийг шинэчлэх замаар агаарт гарах хүчлийн хийг багасгах		
	Агаарын чанар, төлөв байдлын өөрчлөлтөд тавих хяналт-шинжилгээ, мэдээллийн чанарын түвшинг дээшлүүлж агаарын бохирдлыг багасгана	хот, суурингийн доторхи авто замыг хатуу хучилттай болгох ажлыг ээлж дараатай хэрэгжүүлэх	Агаарын чанар, төлөв байдлын өөрчлөлтөнд тавих хяналт сайжирч, томоохон төв, суурин газруудын агаарын бохирдлын хэмжээ буурч, агаар бохирдуулагчидтай тэмцэх арга хэлбэр боловсронгуй болно	2006-2010
		төв, суурин газрын хот байгуулалтын төлөвлөлтөд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, усан сан, усан оргилуур барьж байгуулах, агаар бохирдуулагч эх үүсвэр бүхий объектын байршлыг салхи, уур амьсгалын нөхцөлтэй уялдуулан шийдвэрлэх		

		аж ахуйн нэгж, байгууллага, айл өрх, иргэдийн дунд гудамж талбайг зүлэгжүүлэх, мод сөөг тарих ажлыг зохион байгуулах		
		хог хаягдал, бохир усыг задгай хаях, шатаах явдлыг бүрэн зогсоох		
		бохирдуулагч бодис ялгаруулж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний газрын техник, технологийн зарчмыг үндэслэн ажил, үйлчилгээ явуулах зөвшөөрөл олгодог журамд шилжих		
		агаар бохирдуулагч эх үүсвэрийн үйл ажиллагаанд технологийн хяналт бий болгосноор байгаль орчин, хүний эрүүл мэнд, эдийн засагт үүсгэсэн хохирлыг бохирдуулагч нь нөхөн төлөх, бохирдлыг багасгах зардлыг хариуцах эрх зүйн үндсийг бий болгон мөрдөж эхлэх		
		Орхон аймагтай хамтарч уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах “Цагаан тоос” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх		
	Хот, суурин газрын агаарын бохирдлыг эрс бууруулж олон улсын стандартын түвшинд хүргэнэ	сумын төвүүдийн ус, цаг уур, орчны шинжилгээний салбаруудыг агаарын бохирдлыг хэмжих багаж, тоног төхөөрөмжөөр хангах	Агаарын чанар, төлөв байдал, уур амьсгалын өөрчлөлтөнд тавих хяналт сайжирч, аймаг бүсийн мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болно	2011-2020
		авто тээврийн хэрэгслийн агаар бохирдуулагч бодист хяналт тавих техник оношилгооны цэгийг аймгийн төвд байгуулж, утаа тортог их хаядаг тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулдаггүй болгох		
		гэр хорооллын айл өрхийг бүрэн шаталттай зуух, түлшээр хангах		
		эрчим хүчний системийг байгаль орчинд хоргүй тоног төхөөрөмжөөр шинэчлэх, нар, салхи, ус зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах арга хэмжээг төсөл шалгаруулах замаар хэрэгжүүлэх		
		үйлдвэрийн хаягдлыг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хаягдалгүй болон дахин боловсруулах техник, технологи нэвтрүүлэх		
4.6 Биологийн төрөл зүйлийн ашиглалт, хамгаалал				
	Биологийн төрөл зүйлийн төлөв байдал, нөөц,	аймгийн биологийн төрөл зүйлийн байдал, нөөц, ашиглах боломж, хамгаалах талын судалгааг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хийж, экологи-эдийн засгийн үнэлгээ өгөх	Аймгийн хэмжээнд биологийн төрөл зүйлийн хэвийн өсөлтийг хангах суурь	2006-2010

	<p>хомсдолын шалтгаан, үр дагаврыг тодорхойлж, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх эрх зүйн орчин, нийгэм-эдийн засгийн механизмыг бүрдүүлэн, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлнэ</p>	<p>агнуурын үндсэн хөхтөн амьтдын тооллого хийх, тархалтыг тогтоож, нуур, гол мөрнүүдийн загасны нөөцийн судалгааг хийх</p>	<p>нөхцлийг бүрдүүлнэ</p>	
		<p>экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалахад онцгой үүрэг бүхий амьтан, ургамлын зүйлийг судлах, сэргээн нутагшуулах, тарималжуулах ажлыг зохион байгуулан хэрэгжүүлж эхлэх</p>		
		<p>сум бүрийн газар ашиглалтын төлөвлөлтөд биологийн төрөл зүйлийн амьдрах орчныг хамгаалах асуудлыг тусган хэрэгжүүлэх</p>		
		<p>устаж болзошгүй төрөл, зүйлийг хамгаалах арга хэмжээ авах. “Заан хүж” хүжийг түүхийг гурван жил хориглох</p>		
		<p>хөдөө аж ахуй, уул уурхай, ойн үйлдвэрлэлээс биологийн төрөл зүйлд үзүүлж байгаа нөлөөллийг тодорхойлж, хамгаалах журам боловсруулан мөрдөх</p>		
		<p>доройтсон орчинг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж, бэлчээрийн талхлагдлыг хязгаарлан, байгалийн аясаар нөхөн сэргээх нөхцлийг бүрдүүлэх</p>		
		<p>аж ахуйн гоц ашигт амьтныг өсгөн үржүүлэх, ургамлыг нутагшуулан тарималжуулах ажлыг эхлүүлж, биологийн нөөцийн хомсдлыг хязгаарлах</p>		
		<p>хөнөөлт шавьж, мэрэгчидтэй байгаль орчинд хоргүй аргаар тэмцэх</p>		
		<p>байгаль хамгаалагчдын мэдлэгийг дээшлүүлж, техник хэрэгслээр хангах шат дараалсан арга хэмжээ авах</p>		
		<p>аймгийн биологийн баялгийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авах</p>		
	<p>Биологийн төрөл зүйлийн хэвийн өсөлтийг хангах орчинг бүрдүүлж, хяналтын тогтолцоог</p>	<p>амьтан, ургамлын хүрээлэн байгуулах</p>	<p>Биологийн төрөл зүйлийн хэвийн өсөлтийг хангах таатай орчин бүрдэж, хамгаалах, оновчтой ашиглах менежмент сайжирна</p>	<p>2011-2020</p>
		<p>бололцоотой бүх нуур, голд загас өсгөн үржүүлэх</p>		
		<p>нэн ховор, ховор буюу устах аюулд орсон амьтан, ургамлыг зориудаар өсгөж үржүүлэн, тэдгээрийн амьдрах орчны доройтлыг хязгаарлан зогсоож, удмын санг хадгалах</p>		

	сайжруулна	нөөц нь тогтоогдсон зарим зүйлийн амьтныг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахдаа уг төслийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамруулах талаар аж ахуйн арга хэлбэрийг сонгон хэрэгжүүлэх		
		биотехнологийн аргыг өргөн хэрэглэх замаар эмийн болон онц ашигт ургамлын плантаци байгуулах		
		амьтан, ургамлын мэдээллийн сан байгуулах		
		ангийн аж ахуй эрхлэх, эмчилгээ болон хүнсний зориулалтаар хэрэглэгддэг эмийн ховор ургамлыг таримал байдлаар үржүүлж орлого олох боломжийг иргэд, байгууллагад олгох		
4.7 Байгалийн гамшгийн аюулыг бууруулах талаар				
	Аймгийн эдийн засаг, нийгмийн гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг шинжлэх ухааны үндэслэл бүхий аргачлалаар тооцон гаргаж, хөгжлийн чиг хандлагатай уялдуулан бууруулах	Хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар салбар бүрийн эрсдэл, эмзэг байдлыг тодорхойлон түүнийг багасгах арга хэмжээ авах	Хөгжлийн төлөвлөлт бодитой болж тогтвортой хөгжих боломж бүрдэнэ	2006-2010
		Гашиг ослын эмзэг байдлыг үүсгэж буй нөхцөл байдлыг нарийвчлан тогтоож, түүнд нөлөөлж буй хүний хөгжлийн болон удирдлага зохион байгуулалт, эдийн засаг, нийгмийн хүчин зүйлүүдийн нөлөөллийг тогтоох		
		Онцгой байдлын албаны чадавхийг дээшлүүлэх		
		Сумдад гамшиг ослын голомтонд ажиллах шуурхай бүлгүүдийг байгуулж бэхжүүлэх, сурган дадлагажуулж, шаардлагатай багаж зэвсгээр хангах		
		Аймгийн нөөцийн салбарыг өргөтгөн зохион байгуулах		
		Гамшгийн мэдээллийн сан байгуулан гамшиг осол бүрийн хохирлыг нарийн тооцож, иргэдэд таниулах, урьдчилан сэргийлэх ажилд хэвлэл мэдээллийн хэрэгслийг үр дүнтэй ашиглах		
	Байгалийн гамшгийн аюулын эрсдэл, эмзэг	Нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах чиглэлээр үнэлгээ өгч, хэрэгжилтийг хангах үйлчилгээ үзүүлэх	Байгалийн гамшгийн эрсдэл, эмзэг байдал буурч түүнээс	2011-2020

	<p>байдлыг бодитой бууруулах боломжийг хангах</p>	<p>Цаг уурын хэмжилтийн цэгийн нягтрал, тэдгээрийн хэмжилтийн тоо хэмжих элементүүдийг нэмэгдүүлэх, цаг уурын аюулт үзэгдэл, байгаль орчны шаардлагатай хэмжилтүүдийн дүнг гамшгийн аюулыг бууруулах үйл ажиллагаанд ашиглах боломжийг ихэсгэх, чичирхийллийн станцын техникийн шинэчлэл хийх</p>	<p>учрах хохирлын хэмжээ багасна</p>	
		<p>Хүн малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины хамрах хүрээг нэмэгдүүлж, өвчний голомтонд ажиллах багийн ур чадварыг нэмэгдүүлэх, эм бэлдмэл хамгаалалтын хэрэгслийн нөөц бүрдүүлэх</p>		
		<p>Ой хээрийн түймрийг бага талбайд богино хугацаанд мэдээлэх технологийг нэвтрүүлэн, орчин үеийн унтраах арга технологи, техникийг ашиглаж эхлэх</p>		
		<p>Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослын аюулыг урьдчилан мэдээлэх, түүний голомтын нөхцөл байдалд үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор хөрш улсууд болон олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллах</p>		